


APU COMPANY

Absolute. Pure. Unique.



2016
ЖИЛИЙН ТАЙЛАН



01


КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

- Эрхэм зорилго, үнэт зүйлс
- Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ
- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- Үйл ажиллагааны хураангуй

02

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Стратеги
- Зах зээл, өнөөгийн байдал
- Үйл ажиллагаа
- Шинэ болон шинэчилсэн брэндүүд



03

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- Төлөөлөн удирдах зөвлөлийн баг
- Цалин урамшуулалын бодлого
- Компанийн засаглалыг сайжруулах хөтөлбөр
- Хувьцааны мэдээлэл
- Ногдол ашгийн бодлого
- Гүйцэтгэх удирдлагын баг
- Эрсдэлийн удирдлага

04

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- Тогтвортой байдлын бодлого
- Нийгмийн хариуцлага, төсөл хөтөлбөрүүд
- Шагнал

05

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

- Санхүүгийн тайлан
- Тайлагналын зарчим
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид нийгэмд баялаг бүтээх тулгуур хүч нь болж, өөрсдийн гаргасан амжилтаараа хүн, байгаль дэлхий, ирээдүйдээ хувь нэмрээ оруулахад оршино.



БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ



Бизнес эрхлэлт:

Бид бүх шатанд багаар ажиллан хамтран туурвиж, хүмүүсээ зоригжуулан дуудаж, урамшуулан тэтгэн, тэргүүлэгч болохын төлөө эрмэлзэнэ.

Ил тод байдал:

Ил тод байдлыг эрхэмлэн, хийж буй ажилдаа бусдыг татан оруулж, урамшуулахын тулд зорилгоо бүрэн таниулна.

Өвөрмөц байдал:

Бид тулгарсан сорилт бүрийг даван туулж, хамтран ажилладаг түншүүд, нийгэмдээ дэмжлэг үзүүлэх ухаалаг замуудыг эрэлхийлнэ.

Чин шударга байдал:

Бид хийж байгаа зүйлээ үнэнч шударга, ёс суртахууны сахилга баттай гүйцэтгэж, Монгол улсын байгалийн баялгийг хойч үедээ өвлүүлэн үлдээж, дээд зэргийн стандартуудыг эдийн засаг, нийгэм, байгаль орчинд нэвтрүүлж, цаашид улам хөгжүүлэхийн төлөө ажиллана.

ТҮҮХЭН ТОВЧООН

1924

Монгол Ардын Намын Төв хорооны V хурал, Ардын засгийн газрын VII хурлаар "Архины онц эрхийг улсын санд авах тухай" дүрмийг баталжээ. Ийнхүү Улаанбаатар хотод 14 ажилтантай архины анхны үйлдвэр нээгдэв.

1958

Шар айрагны үйлдвэрт хөргөлт, даралтат хийн тоног төхөөрөмжийг шинээр суурилуулж, цагт 3000 шил шар айраг савлах хүчин чадалтай механикжсан урсгал шугамыг ашиглалтанд оруулан, техник технологийн дэвшилт хийв.

1972

ЗХУ-ын тусламжтайгаар Архи, пивоны комбинатын барилга, тоног төхөөрөмж, шугам сүлжээний угсралтын ажлыг бүрэн дуусгаж, тохируулга, туршилтын ажлыг хийж, 1972 оны арванхоёрдугаар сарын 31-ний өдөр БНМАУ-ын Засгийн газрын актаар байнгын ашиглалтанд оруулжээ. Шар айрагны "Нийслэл" брэндийг худалдаанд гаргав.

1973

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1973 оны нэгдүгээр сарын 12-ны өдрийн 10-р тогтоолоор Архи пивоны төв үйлдвэрийг Улаанбаатарын Архи пивоны комбинат (АПК) гэж нэрлэхээр тогтов.

1992

Архи, пивоны комбинатыг АПУ ХК болгон зохион байгуулж, нийт хувьцааны 51 хувийг төрийн мэдэлд үлдээж, 49 хувийг хөрөнгийн биржээр арилжаалав.

Чех улсын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар шар айраг үйлдвэрлэж эхэлсэн.

1927

Хийжүүлсэн амтат ундаа, Жанчивлангийн рашаан савлах цехийг шинээр байгуулав.

1961

Ардын хувьсгалын 50 жилийн ойгоор үйлдвэрлэл, үйлчилгээний ажлыг сайн зохион байгуулж, оногдсон үүргээ амжилттай биелүүлсэн учир Архи пивоны төв үйлдвэрийг БНМАУ-ын Засгийн газрын "Хүндэт жуух бичиг"-ээр шагнав.

1971

Архи пивоны комбинат 1976 оноос эхлэн 5 жил дараалан Улсын тэргүүний үйлдвэрээр шалгарч, төрийн дээд шагнал "АЛТАН ГАДАС" одонгоор шагнуулжээ. Монгол хүн анх удаа сансарт ниссэн үйл явдалд зориулан дээд зэргийн "Болор" архийг хэрэглэгчдэдээ хүргэж эхэллээ.

1981

2003

Шар айрагны үйлдвэрийн хуучин барилга, шугам сүлжээ, техник, технологид иж бүрэн шинэчлэл хийж, жилд 20.0 сая литр шар айргийг шил болон ган торхонд савлах хүчин чадалтай үйлдвэрийг ашиглалтад оруулав. Монголын анхны шилтэй хар пиво "Хар Хорум" болон дээд зэрэглэлийн "Алтан Говь" шар айраг худалдаанд гарлаа. Мөн "Ерөөл" брэндийг зах зээлд гаргав.

2006

АПУ ХК сүү, жимсний шүүсний үйлдвэрийг байгуулжээ. Мөн Тетра-Пак бүрэн автоматжсан шугамын хамт "Цэвэр Сүү" брэндийг хэрэглэгчдэд танилцуулсан. "Ерөөл" болон "Алтан Түрүү" брэндүүдийг амжилттай шинэчлэв.

2009

Герман улсын техник, технологиор тоноглогдсон компьютерийн хяналт удирдлагатай, орчин үеийн Спиртийн шинэ үйлдвэр "Натур-Агро"-г улсын комисс хүлээн авч, ашиглалтад оруулжээ. Залуусын брэнд "Fusion" шар айраг болон хүүхэд залуусын уух дуртай "Фрутта" жимсний шүүсийг зах зээлд нэвтрүүлэв.

2014

Сүү, сүүн бүтээгдэхүүнийг боловсруулах тоног төхөөрөмжөөр дэлхийд тэргүүлдэг Германы ГИА (GEA) компанитай хамтран сүүний шинэ үйлдвэрийг байгуулж ашиглалтад оруулав. АПУ компани 90 жилийн ойгоо хийж бүтээсэн, шинэчлэн санаачилсан, ололт амжилтаа бататгаж, өнгө төрхөө шинэчлэн АПУ Company болов.

11 дүгээр сард Монгол Улсын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн хувьчлалын салхийг хагалж, компанийн төрийн мэдэлд байсан 51 хувийн хувьцааг дуудлага худалдаанд оруулснаар АПУ ХК хувийн өмчид бүрэн шилжив.

2001

Ус, ундааны үйлдвэрийн хуучин барилга, шугам сүлжээ, техник, технологид иж бүрэн шинэчлэл хийж, жилд 4.5 – 5.0 сая литр бүтээгдэхүүнийг 0.33 л, 0.5 л, 1.5 л, 2 л-ийн хуванцар саванд савлах хүчин чадалтай үйлдвэрийг ашиглалтад оруулжээ. "АПУ Цэвэр ус"-ны брэндийг хэрэглэгчдийн гарт хүргэлээ.

2004

Супер премиум зэрэглэлийн "Соёмбо" сархадых зах зээлд нэвтрүүлээ.

2007

Шингэн хүнсний салбарт шинэ технологи, стандартыг нэвтрүүлсэн шар айрагны шинэ үйлдвэрийг, агуулахын стандартад дэвшилт гаргасан бүрэн автомат "АПУ Ложистик" төвийг тус тус бүтээн байгуулав. "Оргилуун" хийжүүлсэн усны брэндийг анх удаа Монголын зах зээлд нэвтрүүлсэн. Монголчуудын эртний танил "Боргио" шар айраг бүрэн шинэчлэгдэв.

2013

"Шинэ давалгаа"-г зах зээлд нэвтрүүлэх зорилтын хүрээнд D-тэй сүү, Bliss жимстэй шар айраг, VELVET, EDEN, ARKHI EXPORT /40 жил/, Тайга /4 төрөл/, Охь зэрэг архины 5 брэндүүдийг зах зээлд шинээр нэвтрүүлэв.

2016

БИДНИЙ БАРИМТЛАЛ

Төгс, төгөлдөр, тунгалаг Absolute, Pure, Unique

Монголын уламжлалт нүүдэлчдийн соёл, гүн ухаанд хурмаст тэнгэрийг цэвэр хязгааргүйн билэгдэл, хөвчин дэлхийн онгон байгалийг цаг хугацаа, оюун ухааны хосгүй нэгдэл гэж үздэг. Энэ хоёр ижилгүй шинж нийлэн цэвэр ариун чанарыг он удаан жил хадгалж иржээ. “Төгс, Төгөлдөр, Тунгалаг” гурвалыг “Хамгийн Шилдэг”-ээ дээдлэх Монгол уламжлалаар “Дээж” болгон өргөн барьж байна. Энэхүү итгэлийг бид бизнесийнхээ цөм болгон, хийж байгаа бүхнээ улам сайжруулахыг эрмэлздэг. Бидний хөрөнгө оруулалтаар боссон бизнесийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ бид үйлчлүүлэгч нартаа болон нийгэмдээ зориулан цаг үргэлж боловсронгуй болгохоор ажиллах болно.



ТӨГС

Үүрэг хариуцлага

- Бид хөгжлийг хөтөлж, нийгмийг манлайлан, зах зээл болон хамтрагчаа хүндэтгэж, үндсэн зорилгоо бүрэн таниулна.
- Компанийн санхүү, мэдээллийг ил тод, үйл ажиллагааг тогтвортой байлгана.
- Монголын тэргүүлэгч ажил олгогч байна.

ТӨГӨЛДӨР

Ёс зүй, орон зай

- Бид хүн, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмэр, үнэт зүйлээ дээдэлнэ.
- Компанийн хөгжил нь үйлдвэрлэлийн шинэ технологи дээр суурилна.
- Бизнесийн ил тод байдал, аюулгүйн нөхцөлийг хангаж ажиллана.

ТУНГАЛАГ

Соёл, бүтээгдэхүүн

- Орчин цагийн зах зээлийг манлайлан тодорхойлж, хүнсний монгол брэндийг бүтээн үйлдвэрлэгч байна.
- Дэлхийн түвшний бизнесийн байгууллагуудтай түншилж, хамтын ажиллагааг өрнүүлнэ.
- Монголын хэл, соёлын өвөрмөц өвийг хадгалан хамгаалж хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ЗАХИДАЛ

АПУ ХК-ийн Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн Дарга

Пүрэвийн БАТСАЙХАН

**Хүндэт хувьцаа
эзэмшигч та
бүхэндээ энэ
өдрийн мэндийг
хүргэе!**

Жил болгон уламжлал ёсоор эрхэм хувьцаа эзэмшигч та бүгдээр урьдах жилийнхээ ажлаа дүгнүүлж, үр дүнгээ тайлагнах цаг дахин ирлээ. 2016 оны хувьд Монгол улсын макро эдийн засгийн таагүй нөхцөл байдал үргэлжилж, төгрөгийн ханш ихээхэн суларсан, нийт хэрэглээний зах зээл хумигдсан хүндхэн жил байв.

APU компанийн хамт олон хүлээсэн үүрэг, амласан амлалтаа биелүүлж, тулгарсан сорилтоо нэр төртэй даван туулахаар шамдан, архи, шар айрагны зах зээлд шинэ брэнд бүтээгдэхүүнүүдийг нийлүүлэхийн зэрэгцээ зардал хэмнэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүллээ. Төгрөгийн ханш 2016 оны эхтэй харьцуулахад 20 гаруй хувь суларсан нь компанийн цэвэр ашиг өмнөх оныхоос үлэмж буурахад нөлөөлсөн ч уламжлал ёсоор нийт хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг тараах шийдвэр гаргасныг та бүхэнд дуулгахад таатай байна.

2017 онд Монгол Улсын Засгийн Газраас хэд хэдэн төрлийн татварын хувь хэмжээг нэмж, халамжийг танах болсноо зарлалаа. Энэ жил эдийн засгийн нөхцөл байдал хамгийн хүнд үедээ, өсөлтийн хувьд хамгийн доод цэгтээ хүрч, ирэх 2018-2019 онуудад эргэн сэргэх хүлээлт байгааг шинжээч нар онцолж байна. Бүх нийтээрээ "бүсээ чангалах" шаардлага тавигдаж, дотоод нөөц бололцоогоо дайчлан, хүнд үеийг даван туулах сорилт бидний өмнө байна. Үндэсний манлай үйлдвэрлэгч, шилдэг татвар төлөгч, Монголын ууган хувьцаат

компанийн хамт олон бид компанийн үнэ цэнийг өсгөн нэмэгдүүлэх, хөгжин дэвжих хэтийн зорилгоо умарталгүй, богино хугацаандаа зардал хэмнэх, ажлын байрыг хадгалах, ажилчдынхаа нийгмийн асуудлыг анхаарахад төвлөрөн ажиллах болно.

Аливаа хүндрэл бэрхшээл өөрөө шинэ боломжийг бий болгогч хүчин мөн билээ. Бид хэзээд шинийг эрэлхийлж, шинэ бүтээгдэхүүн, шинэ зах зээл, шинэ гарцыг нээдэг, бүтээдэг, манлайлдаг уламжлалаа үргэлжлүүлнэ. Хүндэт хувьцаа эзэмшигч, найдвартай түнш, үнэнч хэрэглэгч та бүхний дэмжлэгтэйгээр АПУ компани цаг зуурын хүндрэл бэрхшээлийг ажралгүй давж, хөгжлийн шинэ шатанд гарна гэдэгт бүрэн итгэлтэй байгаагаа энэ дашрамд илэрхийлье.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ

АПУ ХК-ийн
Гүйцэтгэх захирал

Цэвээнжавын ЭРДЭНЭБИЛЭГ

**Эрхэм хувьцаа
эзэмшигчид,
харилцагчид,
түнш
байгууллагууд
болон
хөдөлмөрч хамт
олондоо энэ
өдрийн амар
мэндийг эрэн
мэндчилье!**

2016 он улс төр, нийгмийн нөхцөл байдлын өөрчлөлттэй зэрэгцэн, удаан хугацааны санхүүгийн хямрал, эдийн засгийн тогтворгүй байдал үргэлжилж, үндэсний үйлдвэрлэгчдийн хувьд хүндхэн сорилтыг даван туулсан амаргүй жил байлаа. Гэсэн хэдий ч томоохон үйлдвэрлэгчдийн нэгэн адилаар АПУ компани нь салбартаа тэргүүлэгчийнхээ байр суурийг хадгалж, улс орны хөгжилд өөрсдийн хувь нэмрээ бодитойгоор оруулан ажилласныг дурдах нь зүйтэй. Тэр дундаа засаглалаа сайжруулж, тогтвортой ажлын байраар ханган, нийт ажилчдынхаа хувь хүний хөгжилд хөрөнгө оруулалт хийж, эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор “Төгөлдөр” төслийг хэрэгжүүлж, ажилтан бүрийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх тал дээр бодлогын хүрээнд анхаарч ажиллаа.

Компанийн хувьд өнгөрсөн онд үр ашгаа нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлж, чанар, хүнсний аюулгүй байдалд анхаарч, олон улсын стандартуудыг баримтлан ажилласны үр дүнд Bliss, Prime, VELVET, EDEN, ARKHI EXPORT /40 жил/, Тайга /4 төрөл/, Охь, “Д” амин дэмтэй сүү зэрэг шинэ шинэлэг брэнд бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нийлүүлж, нийт 162 нэр төрлийн 92 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэн, 327* тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн төдийгүй Монгол улсын төсөвт 127 тэрбум төгрөгийн татварыг төлсөн байна. Түүнчлэн нэгж хувьцааны ханш 2016 оны эхэн үетэй харьцуулахад оны эцэст 3%-р өссөн үзүүлэлттэй байж /хуваасан ханш руу хөрвүүлж тооцсон/, бид

олон улсын банк санхүүгийн байгууллагад нийт 16 сая ам долларын эргэн төлөлтийг гүйцэтгэн, үйлдвэрлэлдээ 3 тэрбумын хөрөнгө оруулалтыг хийжээ.


Цаашид үр ашгаа нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх тал дээр анхаарч, 2017 онд 124 нэр төрлийн 94 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 339* тэрбум төгрөгийн борлуулалт хийхээр төлөвлөөд байна. Мөн олон улсын банк санхүүгийн байгууллагад нийт 16 сая ам долларын зээлийн эргэн төлөлтийг гүйцэтгэж, экспортыг нэмэгдүүлэх тал дээр дэвшил гаргаж, бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн тасралтгүй, тогтвортойгоор явуулж, стратегийн бодлогын хүрээнд зорилтуудаа биелүүлэн ажиллах болно.

АПУ компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол түмнийхээ өв соёл, ёс уламжлалыг хойч ирээдүй болсон хүүхэд залуустаа таниулах зорилготой уялдуулан ажиллаж, нийт ажилчдын дунд “Соёлоор гоёно” уриатайгаар “Төгөлдөр” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Бидний үйл ажиллагааг үргэлж дэмжиж ирсэн хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түнш байгууллагууддаа талархал дэвшүүлэхийн хамт цаашид бидний нийгмийнхээ өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа эрхэмлэн, чадварлаг боловсон хүчин бэлтгэж, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл эрхлэн, эдийн засгийн тогтвортой хөгжлийг цогцлоох үйлсэд хамтын ажиллагаагаа улам бүр батжуулан, хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

* НӨАТ, ОАТ орсон дүн болно.






2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ


Цэвэр борлуулалтын орлого
(тэрбум төгрөг)

-1%




Үйл ажиллагааны ашиг
(тэрбум төгрөг)

6%




Цэвэр ашиг
(тэрбум төгрөг)

-73%




Борлуулалтын тоо хэмжээ
(сая.литр)

-2%




Бүтээгдэхүүний нэр төрөл
(SKU)

19%



Нийт ажилчдын тоо

-7%



2016 ОНЫ ҮР ДҮН БОЛ БИДНИЙ СТРАТЕГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОВЧТОЙ
БАЙДАЛ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ЮМ.

		2016	2015	Өөрчлөлтийн %
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТОО ХЭМЖЭЭ	мян.литр	92,850	94,533	-2%
БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ	мян.литр	88,445	90,606	-2%
ОРЛОГО ҮР ДҮН				
Цэвэр борлуулалтын орлого	сая.төг	208,055	210,111	-1%
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	36,152	34,204	6%
Цэвэр ашиг	сая.төг	2,883	10,670	-73%
БАЛАНС				
Нийт хөрөнгө	сая.төг	291,070	305,672	-5%
Нийт өр төлбөр	сая.төг	147,884	160,178	-8%
Нийт эздийн өмч	сая.төг	143,185	145,494	-2%
Нийт эздийн өмч ба өр төлбөр	сая.төг	291,070	305,672	-5%
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	47,757	40,308	18%
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(2,965)	(4,689)	-37%
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(35,132)	(38,862)	-10%
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	9,660	(3,243)	-398%
ТАТВАР ТӨЛӨЛТ				
ОАТ	сая.төг	90,420	90,790	0%
НӨАТ	сая.төг	19,119	19,274	-1%
Бусад	сая.төг	17,422	14,599	19%
Нийт		126,961	124,662	2%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ				
Нийт хөрөнгө оруулалт	сая.төг	2,977	5,021	-41%

ТАТВАР ТӨЛӨЛТ


APU компани нь 2016 онд Монгол улсын нэгдсэн төсвийн орлогод 127 тэрбум төгрөгийн татвар төлсөн ба үнээс онцгой албан татварын орлогод 90 тэрбум, нэмэгдсэн өртгийн албан татварын орлогод 19 тэрбум тус тус төлсөн байна.



Монгол улсын нэгдсэн
төсвийн орлого



Онцгой албан
татварын орлого



Нэмэгдсэн өртгийн албан
татварын орлого



APU КОМПАНИЙН 2016 ОНД МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН НИЙТ ТАТВАРЫН ОРЛОГООР ЮУ ХИЙЖ БОЛОХ ВЭ?



Эх сурвалж: Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ батлах тухай ЗГ 336-р тогтоол, Үндэсний Статистикийн Хороо, Байгаль орчин, аялал жуулчлалын яам

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



СТРАТЕГИ



Бид 2016 онд компанийн хэмжээнд дараах нэн тэргүүний асуудлуудыг дэвшүүлж ажилласан.

ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН
ӨГӨӨЖИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ



ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ
ХУВИЙГ ОНОВЧТОЙ
ТҮВШИНД БАРИХ



БИЗНЕС ПРОЦЕССИЙГ
СТАНДАРТЧИЛАХ



МЭДЭЭЛЛИЙН
УРСГАЛЫГ
САЙЖРУУЛАХ



САНХҮҮГИЙН БАРИМТЛАХ СТРАТЕГИ

Үр ашигт байдалд чиглэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, бүх түвшний үйл ажиллагаан дахь хэмнэлтийн стратеги.

Зах зээлд эзлэх хувиа хадгалах болон нэмэгдүүлэх замаар борлуулалтын орлогын өсөлтийг бий болгох стратеги.

ХЭРЭГЛЭГЧ БА МАРКЕТИНГИЙН СТРАТЕГИ

Брэндийн цогц бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэнд мониторинг хийж тогтвортой байдлыг хадгалах стратеги.

Эцсийн хэрэглэгчдэд брэндийн бодлогын баримт бичгийн дагуу олон хувилбарт маркетингийн техникүүдийг ашиглан брэндийг зөв таниулах стратеги.

БИЗНЕС ПРОЦЕССИЙН БАРИМТЛАХ СТРАТЕГИ

Процесс дээр суурилсан удирдлагын тогтолцоо бүхий оновчтой орон тоо бүтэц зохион байгуулалттайгаар, бага цаг хугацаа зарцуулж, өндөр бүтээмжтэй, зардал багатай үйлдвэрлэлийн нэгдсэн систем нэвтрүүлэх стратеги.

Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл мөн ашиглалтын зардлыг бууруулах зорилгоор цэвэр ус болон эрчим хүчний зарцуулалтын хэмжээг бууруулан, үйлдвэрлэлд ашигласан усыг дахин ашиглан ажиллах стратеги.

ХҮНИЙН НӨӨЦ, ХӨГЖЛИЙН БАРИМТЛАХ СТРАТЕГИ

Ажилтны бүтээмжид нөлөөлөх байгууллагын соёлын орчин, байгууллагын сэтгэл зүй, хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлж, чадварлаг хүний нөөцийг дотоод болон гадаад орчинд сургаж хөгжүүлэн бүтээмжийг дээшлүүлэх стратеги.

Байгууллагын нэгдсэн зорилго зорилтонд хүрэхийн тулд бизнесийн нэгж бүрийн удирдлага, дунд болон дээд шатанд манлайллыг түгээх, ажилчдыг идэвхижүүлэх, мэдээллийн урсгалыг сайжруулах стратеги.

ЗАХ ЗЭЭЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Олон улсын зах зээлд шингэн сүүний хэрэглээ эрүүл мэндэд тустай гэдэг утгаараа өдөр тутмын, тогтмол хэрэглээ болох хандлага улам бүр өсөн нэмэгдэж байгаа ба үүнийг дагаад үйлдвэрлэл, нийлүүлэлт ч өссөөр байна. 2025 он гэхэд нийт сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн багтаамж 2016 онтой харьцуулснаар 208 тэрбум литр буюу 25 хувиар нэмэгдэх хандлагатай байгаа бол нэг хүний жилийн дундаж сүүний хэрэглээ 13 литр буюу 12 хувиар нэмэгдэх хандлагатай байна. Сүүлийн жилүүдэд олон улсын зах зээлд тослог багатай, нэмэлт тэжээлтэй, амтат сүүний зах зээл огцом өсч байгаа бол шингэн сүүний зах зээлийн өсөлт багасаж тогтворжих төлөвтэй байгаа ч нийт зах зээлийн хамгийн том хэсгийг хадгалсан хэвээр байна. Монгол улсын сүүний зах зээл 2015 онд 7 хувиар буурч байсан бол 2016 онд 1 хувиар өсч нийт зах зээлийн хэмжээ 43,586 мян.л литрт хүрсэн. Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл ийнхүү өсөлттэй гарч байгаа нь монголчуудын хэрэглээ уламжлалт хэрэглээнээс боловсруулж савласан хэрэглээрүү шилжиж, хэрэглэгчдийн хэрэглээний бүтцэд өөрчлөлт орсонтой салшгүй холбоотой. Сүүлийн жилүүдэд импортын шингэн сүүний зах зээлд эзлэх хувь буурч, дотоодын үйлдвэрийн шингэн сүүний нийлүүлэлт өсч 2016 оны байдлаар бараг 100% дотоодын үйлдвэрийн шингэн сүүг хэрэглэж байна.



APU компани нь 2006 онд "Цэвэр сүү" брэндийг зах зээлд нэвтрүүлж, 2014 онд сүүний шинэ үйлдвэрээ нээснээр зах зээлд томоохон байр суурь эзлэх болсон. 2016 оны байдлаар манай компани нийт 32 нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргаснаар Монгол улсын сүүний зах зээлийн 24 хувийг, тараг, йогуртны зах зээлийн 19 хувийг бүрдүүлэн ажиллаж байна.



АРХИНЫ ЗАХ ЗЭЭЛ

Эдийн засгийн нөхцөл байдал, хэрэглэгчдийн хэрэглээний шилжилт зэргээс хамааран дэлхий дахинд архины зах зээлийн өсөлт зогсонги байдалтай хэвээр байна.

Дэлхий дахины энэхүү өөрчлөлт нь Монголын архины зах зээлд ч мөн нөлөөлж байна. 2016 онд Монгол улсын архины зах зээл биет хэмжээгээр 24.41 сая литр хүрч, өмнөх онтой харьцуулахад 1.3 хувиар буурч зах зээлийн бууралтын хувь тогтворжих хандлагатай байна.

Монгол улсын эдийн засгийн байдал, иргэдийн худалдан авах чадвар, хэрэглээний хандлага өөрчлөгдөж байгаатай холбоотой хэрэглэгчид дундаж үнэтэй архинаас илүүтэйгээр хямд эсвэл өндөр үнэтэй архи сонгон хэрэглэх байдал нэмэгдэх болсон.

APU компани нь 2016 оны байдлаар нийт 17 брэндийн 64 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэн гаргаж, хэрэглэгчиддээ хүргэснээр дотоод зах зээлийн 51 хувийг бүрдүүлэн ажиллаж байна.



ПИВОНЫ ЗАХ ЗЭЭЛ

Нийгэм эдийн засгийн өөрчлөлт болон хэрэглэгчдийн хэрэглээний чиг хандлага зэргээс улбаалан шар айрагны борлуулалт 2015 онд 188.3 тэрбум литр байсан бол 2016 онд 0.2 хувиар өсөн 188.6 тэрбум литрт хүрсэн байна. Дэлхийн хэмжээнд шар айрагны хэрэглээ тогтворжих хандлагатай болсон ч Монгол улсын хэмжээнд 2014 оноос хойш зах зээл хумигдаж байгаа.

2016 онд Монгол улсын шар айрагны зах зээл биет хэмжээгээр 100.3 сая литр хүрч, өмнөх онтой харьцуулахад 3.0 % буурсан. 2013 онд манай улсын 16-с дээш насны нэг хүнд ногдох шар айрагны хэмжээ жилд 54 литр байсан бол 2016 он гэхэд энэ хэмжээ 20 орчим хувь буурч 45 литр болсон байна.

Дотоодын шар айрагны үйлдвэрлэлийн хүчин чадал, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, маркетинг ПР эрчимтэй хөгжиж дотоодын бүтээгдэхүүний чанар сайжрахын хэрээр гадны брэнд, импортлогчдод үлдэх орон зай улам бүр багассаар байна. 2016 оны гүйцэтгэлээр Монгол улсын шар айрагны зах зээлийн 20 хувийг импортын бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа ба энэ нь 2013 онтой харьцуулахад 43% буурсан үзүүлэлт юм.

Хэрэглэгчдийн хэрэглээ хандлага, худалдан авах чадварын өөрчлөлтөөс хамааран хямд шар айраг эсвэл өндөр зэрэглэлийн шар айраг хэрэглэх байдал нэмэгдэж дундаж үнэтэй бүтээгдэхүүний зах зээл хумигдаж байна.

APU компани нь 2016 оны байдлаар нийт 12 брэндийн 39 нэр төрлийн бүтээгдэхүүн хэрэглэгчдэд нийлүүлснээр шар айрагны зах зээлийн 57 орчим хувийг бүрдүүлж байна.

УС, УНДАА, ШҮҮСНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн хийжүүлсэн ундааны зах зээл жилд дунджаар 1.4 хувиар өсч 235.6 сая литр хүрсэн бол шүүсний зах зээл 2 % өсч 85.6 сая литр, усны зах зээл 3.7% өсч 282.7 сая литрт хүрсэн. Дэлхийн хэмжээнд худалдаалагдаж байгаа ундааны 30 гаруй хувийг хийжүүлсэн ундаа эзэлдэг боловч сүүлийн жилүүдэд өсөлтийн хурдаар савласан ус, спортын болон функциональ ундаа, энергийн ундаа, байгалийн цэвэр шүүсний хэрэглээ улам бүр өсөн нэмэгдэх хандлагатай байна.

2016 онд Монгол улсын хийжүүлсэн ундааны зах зээл биет хэмжээгээр 157.8 сая литрт хүрч, өмнөх онтой харьцуулахад 16.9% өссөн бол савласан шүүсний зах зээл 10.4% буурч 59 сая литр, савласан усны зах зээл 3.9% өсч 65.6 сая литрт хүрсэн.

Манай улсын хийжүүлсэн ундааны зах зээлийн 9.8%, шүүсний зах зээлийн 25%, савласан усны зах зээлийн 1 орчим хувийг импортын бүтээгдэхүүн эзэлж байна.

APU компани нь 2016 оны байдлаар нийт 6 брэндийн, 27 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нийлүүлснээр хийжүүлсэн ундааны зах зээлийн 2.8%, шүүсний зах зээлийн 3.4%, савласан усны зах зээлийн 6.2 хувийг бүрдүүлэн ажиллаж байна.



ҮЙЛ АЖИЛЛАГАА

APU company нь төлөвлөлт, судалгаа хөгжүүлэлтээс эхлээд түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэлт, тээвэрлэлт ба хадгалалтыг болон бэлэн бүтээгдэхүүн хэрэглэгчдийн гарт очих хүртэл бүхий л үе шатанд хүнсний аюулгүй байдал, чанар стандартыг өндөр түвшинд ханган ажиллаж байгальд ээлтэй үйлдвэрлэлийг эрхэмлэн, салбартаа тэргүүлэгч байсаар ирсэн.



01 ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ

Бид олон улсын дэвшилтэт технологи, ноу-хау, дэлхийн чиг хандлага, инновацийг судлан Монгол ажиллагсад, инженерүүдийн ур ухаанаар Монголын хөрсөнд буулгаж, хэрэглэгч, зах зээлийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцсэн, улмаар тэдний сонирхолыг чиглүүлэх шинэ давалгааг бий болгохоор төлөвлөлт, судалгаа хөгжүүлэлтийг хийж байна.

03 ҮЙЛДВЭРЛЭЛ

APU ОРЦ

Санхүү
Хувь нийлүүлэгчдийн өмч, хөрөнгө, зээл тусламж, хөрөнгө оруулалт



Байгалийн нөөц
Ус, энерги, газар, байгалийн бүтээгдэхүүн

Хүмүүн капитал
Ажиллагсад, эрүүл, аюулгүй байдал, ёс зүйн зарчим

Үйлдвэрлэл
Барилга, үйлдвэрүүд, тоног төхөөрөмж


Нийгэм
Нийгмийн холбоо, хамаарал


Оюуны капитал
Брэнд, судалгаа хөгжүүлэлт, инноваци, үйл ажиллагаа, компанийн нэр хүнд



02 ТАТАН АВАЛТ, НИЙЛҮҮЛЭГЧ ХӨГЖҮҮЛЭЛТ

APU company-н үйл ажиллагаа өргөжин тэлсээр дэлхийд тэргүүлэгч компаниудтай хамтран ажиллаж, туршлага солилцон зөвхөн Монгол улсаар хязгаарлагдахгүй дэлхий олон улсуудыг хамарч байна. Бид үйл ажиллагааны жигд тасралтгүй байдлыг хангахын зэрэгцээ FSSC 22000:2010, ISO 9001:2008 стандартуудыг нэвтрүүлсэн гадаад, дотоодын нийлсэн 140 гаруй нийлүүлэгчдээс түүхий эд материалаа хүлээн авч, хамтран ажилладаг.





06

ХЭРЭГЛЭГЧ



APU company нь дэлхийн стандартад нийцсэн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдож, үйл ажиллагаандаа чанар, аюулгүй байдлын стандартуудыг нэвтрүүлэн ажилласнаар үйлдвэрлэлийн үе шат бүртээ эрчим хүч, дулаан, уур, усны хэмнэлт хийж, хог хаягдлыг бууруулж байгальд ээлтэй үйлдвэрлэгч болж чадсан.

05

БОРЛУУЛАЛТ

APU company-н дээж болсон бүтээгдэхүүнүүд монгол улсын 21 аймаг 329 сум, экспортын 8 улсад, 7000 гаруй харилцагчдаар дамжин хэрэглэгч та бүхэнд хүрдэг. Нийгмийн хариуцлага, зохистой хэрэглээг дэмжин ажиллах зорилгыг нэн тэргүүнд тавьж хуулийн хүрээнд борлуулалтын үйл ажиллагааг гүйцэтгэдэг билээ.

COMPANY



04

ЧАНАРЫН УДИРДЛАГА

APU company нь бүтээгдэхүүнийг зохион бүтээхээс эхлээд түүхий эд материалын чанарыг шалган хүлээн авах, хадгалах, эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн түгээлтэд гаргах хүртэлх бүхий л үйл ажиллагаанд чанар стандартыг өндөр түвшинд ханган ажилладаг ба хэрэглэгчдийнхээ хүсэл сонирхолд нийцсэн, дээд зэргийн чанартай, тунгалаг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн, зах зээлд нэвтрүүлж байна.



2016 ОНЫ АПУ ГАРЦ

Санхүү
Цэвэрт Борлуулалтын Орлого: 208 тэрбум төгрөг
Татвар төлөлт: 127 тэрбум төгрөг
Нийт зарласан ногдол ашиг: 742 сая төгрөг

Байгалийн нөөц
“Эрчим хүчний хэмнэлттэй” Азийн загвар байгууллага
Цэвэр усны хэмнэлт: 11,544м3
Дулаан, эрчим хүчний хэмнэлт: 14.5%

Хүн капитал
Нийт ажилчдын тоо: 817
Ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 1,5 тэрбум төгрөг
Гадаад сургалтын тоо: 46
Дотоод сургалтын тоо: 346

Үйлдвэрлэл
Олон улсын стандартад бүрэн нийцсэн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон 5 үйлдвэр, 1 автомат агуулахтай
Бүтээгдэхүүний нэр төрөл: 162

Нийгэм
Тунгалаг туул аян
Авто ослоос урьдчилан сэргийлэх цуврал “видео”
“Хамаг монгол” Монголын өв, соёлыг хадгалах, түгээн таниулах

Оюуны капитал
ТОП-100 АЖ АХУЙ НЭГЖ
ALUFOIL TROPHY-2016, шинэ, шилдэг шийдэл бүхий бөглөө,
WORLD VODKA AWARDS-2016
Arkhi Export Limited Edition
Vodka /Gold Winner/
Chinggis Khan Vodka /Silver Winner/

СҮҮНИЙ БИЗНЕС НЭГЖ

Жилд 45 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах хүчин чадалтай сүүний үйлдвэрийн боловсруулах хэсэг нь өдөрт 150 тонн бүтээгдэхүүн боловсруулах хүчин чадалтай.

Нийслэлийн хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээг хангах зорилгоор манай сүүний үйлдвэр нь 2014 онд фермийн тоног төхөөрөмж үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч Герман улсын GEA брэндийн тоног төхөөрөмж бүхий боловсруулах хэсэг болон Швед улсын Tetra Pak, Eco-lean савлах шугам, Япон улсын Elorak, EHEDG буюу Европын холбооны сүү боловсруулах үйлдвэрийн стандартын дагуу баригдсан, бүрэн автомат тоног төхөөрөмж бүхий хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт үйлдвэр юм.

Шингэн сүүний худалдан авалт өнгөрсөн онтой харьцуулхад 6 хувь өсч ингэсэнээр зах зээлд шингэн сүүний нийлүүлэлт өссөн ба Фермерүүдийн нийлүүлэлт болон үйл ажиллагааны чанар дээшилж байгаа юм. Олон Улсын Хүнсний Аюулгүй Байдлын удирдлагын тогтолцоо ISO 22000 стандартыг бүрэн хангаж батламжаа авсан манай сүүний үйлдвэр нь Монгол Улсын 300 гаруй фермерүүдээс үнээний цэвэр сүүг тухайн бүс нутгаас тогтвортой үнээр худалдан авдаг. Сүүний үйлдвэр маань Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартын шаардлагыг

бүрэн хангасан сүү, сүүн бүтээгдэхүүнийг батлагдсан технологийн жор, орц, горимын дагуу, анхдагч түүхий эдээс боловсруулан савлаж эцсийн бүтээгдэхүүн болгон бэлтгэн нийлүүлэх үндсэн үйл ажиллагаа явуулж байна.

APU компани нь хэрэглэгчдийхээ эрүүл мэнд, бүтээгдэхүүний чанарт онцгой анхаарал хандуулан ажилладаг ба Монголдоо анх удаа түүхий сүүн дэх антибиотикийн зөвшөөрөгдөх хэмжээг өөрсдийн лабораторидоо хэмждэг болсон.

2016 оны 1 дүгээр сараас Маамуу брэндийг Хонгконгийн зах зээлд экспортоор Wellcome, Park&shop сүлжээ дэлгүүрүүдээр борлуулж эхэлсэн.

Манай компани нь дэлхийд тэргүүлэгч компаниудтай хамтран ажиллаж, туршлага солилцон Монголынхоо хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцсэн шинэ, шинэлэг бүтээгдэхүүн хөгжүүлж хэрэглэгчдийнхээ гарт түргэн, шуурхай хүргэж, эрүүл мэндэд тустай бүтээгдэхүүнээр өдөр бүр ханган ажиллахыг зорьдог билээ.

Энэхүү зорилгынхоо хүрээнд Дээж, Цэвэр сүү, Сайн, Маамуу зэрэг брэндүүдийг үйлдвэрлэн гаргаж, Монголынхоо төдийгүй дэлхийн зах зээлд нэвтрүүлж, хэрэглэгчид дээ хүргэж байна.

АРХИНЫ БИЗНЕС НЭГЖ

Жилд 18.0-20.0 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай.

Герман, Австри, Итали, улсын шилдэг фирмүүдийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон компьютер микропроцессын хяналтын удирдлага бүхий архины үйлдвэрийн архи найрах цех жилд 18.0-20.0 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай. APU компани нь дэлхийн стандартад нийцсэн тоног төхөөрөмж, технологийн хөгжлийг Монголд нутагшуулах хэрэглэгчдийн хүсэл, сонирхол, хэрэглээний онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн бий болгоход брэнд хөгжүүлэлт, инновацийн үйл ажиллагааг чиглүүлэн ажиллаж байна. APU компани нь 2009 онд ХБНГУ-

ын орчин үеийн дэвшилтэт технологи бүхий автомат тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон "НАТУР АГРО" спиртийн үйлдвэрийг ашиглалтанд оруулсан ба уг үйлдвэр нь Монголд төдийгүй дэлхийд тэргүүлэх чанартай "Альфа" зэрэглэлийн спиртийг тогтмол үйлдвэрлэж, компанийн архины үйлдвэрлэлийг жигд тасралтгүй үйл ажиллагаагаар ханган ажиллаж байгаа билээ.

2016 онд "Шинэ давалгаа"-г зах зээлд нэвтрүүлэх зорилгын хүрээнд VELVET, EDEN, ARKHI EXPORT /40 жил/, Тайга /4 төрөл/, Охь зэрэг брэндүүдийг зах зээлд нэвтрүүлэн ажиллаа.

ПИВОНЫ БИЗНЕС НЭГЖ

Жилдээ 75 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай бүрэн автомат үйлдвэр

1927 онд Чех улсын мэргэжилтний оролцоотойгоор эх орондоо анх удаа шар айраг үйлдвэрлэснээр пивоны үйлдвэрийн суурь тавигдаж байсан бол одоогоор Германы Кронес компанийн хамгийн орчин үеийн, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн шаардлагыг бүрэн хангасан техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, жилдээ 75 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай бүрэн автомат үйлдвэр нь ХБНГУ-ын "NERB", Австри улсын "KLINGER" фирмүүдийн тоног төхөөрөмжүүдээр иж бүрэн тоноглогдож, үйлдвэрийн бүх шат дамжлагууд нь

автоматажсан, техник технологийн тухайд ХБНГУ-ын тэргүүлэх 5 үйлдвэртэй ижил түвшинд хүрсэн томоохон үйлдвэр болсон байна.

2016 онд "Шинэ давалгаа"-г зах зээлд нэвтрүүлэх зорилгын хүрээнд Bliss жимстэй, бага градустай пивыг зах зээлд нэвтрүүлэн ажиллаа.

APU компани нь зах зээлийг тэргүүлэгчийн байр сууриа эрхэмлэн, хэрэглэгчдийн хэрэглээг чиглүүлэх, тэдэнд дэлхийн чиг хандлагын инновацийг Монголынхоо онцлогт тохирсон хэлбэрээр нэвтрүүлэн ажиллаж байна.

УС, УНДАА, ШҮҮСНИЙ БИЗНЕС НЭГЖ

Сигма савлах шугам нь цагт 3000 лонх бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд 1.5 литр, 0.5 литр, 0.33 литр ПЭТ, лонхонд бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж байна.

APU компани нь 2004 онд Ус Ундааны үйлдвэрийг бүрмөсөн шинэчлэх анхны төслийн ажлыг хэрэгжүүлэн Европын Холбооны эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан дэлхийн нэртэй фирмүүд болох Австрийн "Клингер", Германы "Косме", "Гернеп", "Фамикс", Италийн "Самса Пак" зэрэг бүрэн автомат тоног төхөөрөмжөөр тоноглогдсон.

2012 онд шинэ ПЭТ савлах шугамын төслийг Герман улсын KRONES компанитай хамтран хэрэгжүүлснээр үйлдвэрийн хүчин чадлыг 4 дахин нэмэгдүүлсэн. Манай үйлдвэр нь Сигма болон Кронес компанийн 2 савлах шугамтай бөгөөд Сигма савлах шугам нь цагт 3000 лонх бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд 1.5 литр, 0.5 литр, 0.33 литр ПЭТ, лонхонд бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж байна. Кронес савлах шугам нь лонхны эзэлхүүнээсээ хамааран цагт 5500-12000 лонх бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай ба 0.5 литр, 1.0 литр,

1.5 литр, 2.0 литр, 2.5 литрийн багтаамжтай ПЭТ, лонхонд пиво, ус, ундаа, шүүсийг савлан гаргаж байна.

Түүхий эд материалаа Герман улсын "Wild", "Dohler" зэрэг дэлхийн нэр хүнд бүхий томоохон компаниудаас химийн ямар нэгэн бордоогоор бордоогүй, байгалийн цэвэр жимснээс гаргаж авсан түүхий эдийг авч хэрэглэдэг. Мөн монгол орны хөрсөнд тарималжуулан ургуулсан эмийн ургамал болох Алтангагнуур, нохойн хошуу, цээнийн үндэс, чихэр өвс зэрэг эмийн ургамлын ханд агуулсан Тэрэлж, Сэлэнгэ ундааг үйлдвэрлэж байна.

Бид ус, ундаа, шүүсний зах зээлд Тэрэлж, Сэлэнгэ, Оргилуун, Фрутта, АПУ цэвэр ус зэрэг олон төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчиддээ хүргэж байна. Бүтээгдэхүүн бүр маань эрүүл мэндэд ашиг тустай чанараараа хэрэглэгчдэд танигдсан гол шалтгаан нь үйлдвэрлэлдээ байгалийн гаралтай ургамал, жимс, жимсгэнэ ашигладагт оршдог.

ЧАНАРЫН БОДЛОГО

Чанарын удирдлага

APU компани нь ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцоо, ISO 14001 Байгаль орчны удирдлагын тогтолцоо болон FSSC 22000 Хүнсний аюулгүй байдлын тогтолцооны баталгаажуулалтын стандартуудыг хамтад нь нэвтрүүлсэн Монголын анхны компани юм. Чанарын удирдлага, хяналтын алба нь бүтээгдэхүүнийг зохион бүтээхээс эхлээд түүхий эд материалын чанарыг шалган хүлээн авах, хадгалах, эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн түгээлтэд гаргах хүртэлх бүхий л процесст сорилт, шинжилгээ, туршилт, чанарын хяналт, баталгаажуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн байнгын мониторингийн хяналт тавьж ажилладаг.

CERTIFIED COMPANY



Бид чанарын бодлогодоо дараах
4 зарчмыг баримтлана.

1

Хууль эрх зүйн болон хэрэглэгчийн шаардлагад бүрэн нийцсэн, хүнсний аюулгүй байдлыг 100 хувь хангасан, дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэнэ.

2

Хүнсний үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд FSSC22000: 2010, ISO 9001:2008 стандартуудын шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, байнгын сайжруулалтыг хангана.

3

Хүний нөөцийн хөгжил, техник, технологид чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж шингэн хүнс үйлдвэрлэлийн манлайлагч компани болно.

4

Хүнсний аюулгүй байдал болон чанарын удирдлагын тогтолцоонд гадаад, дотоод аудитын шалгалт хийх замаар үр дүнг баталгаажуулж ажиллана.



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Итгэмжлэгдсэн лаборатори нь олон улсын стандартын байгууллагаас баталсан стандарт, дүрэм, журам, шинжилгээний арга аргачлал, норматив техникийн баримт бичгүүд болон ISO/IEC 17025 стандартыг мөрдлөг болгон APU компанийн үндсэн 5 үйлдвэрлэлд орж буй үндсэн болон туслах түүхий эд материал, хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүнд итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтын дагуу мэдрэхүй эрхтний, микробиологийн, физик-химийн шинжилгээг үнэн зөв хийж, стандарт шаардлага хангасан, чанартай бүтээгдэхүүн гаргахад, технологийн дамжлага бүрд хяналт тавьж ажилладаг.

Итгэмжлэгдсэн лабораториуд нь олон улсын сорилтын лабораториудын чадавхад тавих ерөнхий шаардлага MNS ISO-17025:2007 стандартын шаардлагыг тогтмол хангаж ажилладаг ба олон улсад лабораторийн тоног төхөөрөмжөөр тэргүүлэгч АНУ, Герман, Австри, Солонгос, ОХУ-ын орчин үеийн шилдэг, нано технологи бүхий өндөр мэдрэмжит тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон. Манай лабораториуд нь үйлдвэрлэлдээ дотоод хяналтыг тавихаас гадна үйл ажиллагааныхаа чиглэлээр Герман улсын VLB, Weihenstephan институт, ОХУ-ын Interlab, ФГБНУ ВНИИПБТ институт, Монгол улсын судалгаа шинжилгээний хүрээлэнгүүд, их дээд сургуулиудтай судалгаа шинжилгээний чиглэлээр хамтран ажилладаг судалгааны томоохон бааз юм.

APU компанийн дотоод хяналтын лаборатори нь дараах бодлогыг баримтална.

Бидний бусдаас ялгарах талууд бол:

- Олон улсын ISO стандартуудыг нэвтрүүлсэн
- Хүнсний аюулгүй байдал, технологийн мэргэшсэн багуудтай
- Чанарын удирдлагын нэгдсэн систем бий болгосон
- Хууль, эрхзүйн нийцлийг бүрэн хангасан
- Процесст суурилсан чанарын мониторингийн хяналтыг бүрдүүлсэн

- Лабораторийн чанарын удирдлагын тогтолцоо болон сорилт шинжилгээний нэгдмэл байдлыг IEC/ISO 17025 стандартын шаардлагад нийцүүлж, байнгын сайжруулалтаар хангана
- Ажилтан ажиллагсдын хөгжил, техник технологид чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг ханган ажиллана
- Болзошгүй санхүүгийн болон бусад хүчин зүйлээс хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулна

2016 ОНД ШИНЭЭР ГАРСАН БРЭНДҮҮД

+Д СҮҮ:



Савлагаа: 0.5л, Тослог: 1.5%

Хүний биеийн дархлаа, ясны эрүүл бүтцэд онцгой ач холбогдолтой Д амин дэмээр баяжуулсан 0.5л-ийн пюрпак савлагаатай "Сайн" сүүг шинээр үйлдвэрлэн гаргалаа. Д амин дэмийн агууламж: 100гр-д 50 IU (олон улсын нэгж)

ОХЬ:



Хатуулаг: 38%, савлагаа: 0.5л, 0.75л

Мэдлэгтэй, мэдээлэлтэй, ухаалаг сонголт хийдэг өөрийн гэсэн ертөнцийг үзэх үзэл, амьдралын хэв маягтай хэрэглэгчиддээ зориулан АРУ компани "Ариун дагшин байгалийн шимт бүхнийг дээжилсэн" цоо шинэ Охь брэндээ хүргэж байна

ТАЙГА



Эгн: Хатуулаг-35%, савлагаа-0.5л, 0.75л
Намар: Хатуулаг-38%, савлагаа-0.5л, 0.75л
Хавар: Хатуулаг-38%, савлагаа-0.5л, 0.75л
Өвөл: Хатуулаг-39%, савлагаа-0.5л, 0.75л

Монгол нутгийн хөрсөнд ургасан ургамал жимсгэнийн ханд бүхий онцгой найрлагатай 4 улирлын онцлогийг хадгалсан байгалийн гаралтай Тайга архийг хэрэглэгч олондоо бэлэг болгон хүргэж байна.

EDEN



Хатуулаг: 36%, Савлагаа: 0.7л, 1л

Өөрийн гэсэн мэдрэмжээр ертөнцийг хардаг, урлаг уран сайхныг таашааж үздэг, зорилго мөрөөдөлдөө үнэнч хэн бүхэнд зориулан АРУ компани "Мэдрэмж хөглөх амт" буюу "EDEN"(ЭДЕН) брэндийг 2016 онд зах зээлд нэвтрүүлээ.

VELVET



Хатуулаг: 38%, Савлагаа: 0.7л, 1л

"VELVET" брэнд нь залуусын цагийг зугаатай, хөгжилтэй өнгөрүүлэх тансаг үдшийн хэв маягийн илэрхийлэл бөгөөд энэхүү бүтээгдэхүүнийг шинийг санаачлах хүсэл эрмэлзэлтэй, өөртөө итгэлтэй эрч хүчээр дүүрэн залуустаа зориулан хүргэж байна.

ARKHI EXPORT



Хатуулаг: 39.5%, Савлагаа: 0.75л

ARKHI брэнд зах зээлд анх гарснаас хойш 40 жилийн ой нь тохиож байгаа бөгөөд уг үйл явдалд зориулж ARKHI EXPORT гэх энэхүү премиум зэрэглэлийн дахин давтагдашгүй дугаарлалт бүхий тансаг идээний дээжийг нийт хэрэглэгчиддээ шинээр өргөн барьж байна.

PRIME



Хатуулаг: 0.46% Савлагаа: 0.45л

Монголын шар айрагны салбарын түүхийн шинэ хуудсыг эхлүүлсэн PRIME лагер шар айраг нь дээд зэрэглэлийн PREMIUM MALTС арвайн соёлжоор исгэгддэг бөгөөд зөөлөн уумтгай чанартай ч жинхэнэ шар айрагны амтыг мэдрүүлнэ.

BLISS



Хатуулаг: 0.4% Савлагаа: 0.33л лонх 0.5л лааз.

BLISS жимстэй шар айраг нь зөөлөн тансаг болоод шүүслэг жимсний өвөрмөц хослолыг хэрэглэгч танд мэдрүүлэх бөгөөд Бэрсүүт жүрж Ханборгоцой, Манго Тоор, ба Лайм Лемон жимснүүдийн төгс хослолыг амтлахыг хүссэн хэн бүхэнд зориулан гаргав.

2016 ОНД ШИНЭЧИЛСЭН БРЭНДУУД

“САЙН” ЙОГУРТ



Савлагаа: 0.5л, Тослог: 1.5%

Гүзээлэгэнэ, хад, ойн жимстэй йогуртууд нь жимсний зөөлөн ширхэгтэйгээс гадна *Bulgaricus*, *Str. Thermophilus* пробиотикүүдээр баялаг йогурт юм. Бүтээгдэхүүнээ шинэчлэн гаргахдаа бид йогуртнуудынхаа сахарын агуулжгийг бууруулж, жимсний амтыг нь илүү тодотгож өгсөн.

“САЙН” БИФИДО ТАРАГ



Савлагаа: 0.5л, Тослог: 1.5%

“Сайн” бифидо тараг нь *Bifidobacterium*, *L. acidophilus*, *Str.thermophilus* пробиотикүүдээр баялаг учраас ходоод гэдэсний үйл ажиллагааг дэмжиж, илүүдэл жин болон хоол боловсруулах эрхтний өвчлөлөөс сэргийлэх бүтээгдэхүүн юм.

“САЙН” ЗӨӨХИЙ



Савлагаа: 0.5л, Тослог: 1.5%

“Сайн” зөөхий нь үнээний шинэхэн сүүний цэцгийг дээд зэргийн хөрөнгөөр бүрэлдүүлж үйлдвэрлэдэг, хэрэглэгчдийн таашаалыг хэдийнээ хүртсэн бүтээгдэхүүн юм.

НИЙСЛЭЛ



Савлагаа: 0.5л, Тослог: 1.5%

Анх 1972 онд зах зээлд гарч байсан Их хотын шинэлэг байдал, шинэхэн шар айргийг мэдрүүлэгч Нийслэл брэнд нь 2010 онд дахин зах зээлд нэвтэрч 2016 онд дизайны шинэчлэлийг бүрэн хийж хэрэглэгчдийн гарт хүрлээ.

УЛААНБААТАР



Савлагаа: 1л, 0.75л

“Улаанбаатар” брэндийн шоггонд орчин үеийн дизайны элементүүдийг оруулж, илүү минимал

BOLOR LIMITED EDITION



Савлагаа: 1л, 0.75л

Орчин үеийн, шинэ, өнгөлөг загварын сливер шогготой 1л, 0.75л “Болор” архийг цөөн тоогоор үйлдвэрлэн гаргасан.

“МААМУУ” БРЭНД



Савлагаа: 0.5л, Тослог: 1.5%

Хүүхдэд зориулсан “Маамуу” брэндийн алим, олон жимстийн шүүсийг багачуудын сонирхолд нийцүүлэн загвар дизайныг нь шинэчлэн гаргасан. Мөн бүтээгдэхүүнд агуулагдах нүүрс ус, тэр дундаа, сахарын хэмжээг бууруулан хүүхдийн эрүүл мэндэд илүү тустай болгосон юм. Хөгжилтэй, ухаантай маамуунууд маань одоо илүү ганган боллоо.

ТОМООХОН ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД



ЗАСАГЛАЛ



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

APU компани бол 3,785* хувьцаа эзэмшигчидтэй, хувьцаа нь нийтэд арилжаалагддаг нээлттэй хувьцаат компани бөгөөд Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны бүртгэлийн нэгдүгээр (I) ангилалд багтах компани юм. Компанийн эрх барих дээд удирдлага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд түүний чөлөө цагт удирдлагын эрхийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдсон 9 гишүүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлэх ба өдөр тутмын удирдлагыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон Гүйцэтгэх захирал эрхлэн явуулдаг.

APU компани нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Компанийн засаглалын кодексийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

2016 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

1

APU компанийн нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 74,287,700 ширхэг хувьцааг 10 хувааж нэг бүр нь 10 мөнгөний нэрлэсэн үнэ бүхий 742,877,000 ширхэг энгийн хувьцаа болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан;

2

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн үнэт цаасны бүртгэлийн ангиллыг шинэчлэн тогтоосны дагуу APU компанийн ангилал өсч I ангилалд багтах бүртгэлтэй компанийн жагсаалтад орсон;

3

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй төрийн болон хувийн хэвшлийн хувьцаат компаниудын дунд зохиогдсон Улсын хэмжээний анхдугаар “Шилдэг жилийн тайлан шалгаруулах” уралдаанд “APU компанийн 2015 оны жилийн тайлан” шалгарч тэргүүн байр эзэлсэн

* ҮЦТХТ ХХК-аас 2017 оны 03 дугаар сарын 09-ны өдрөөр тасалбар болж гаргасан Үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БАГ

ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

APU компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) 9 гишүүнээс бүрдсэн бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлыг төлөөлж компанийн үйл ажиллагааг удирдлагаар хангах, хянах үүрэгтэй. Өөрийн чиг үүргийг гүйцэтгэхдээ, ТУЗ нь Компани, түүнтэй харилцан хамааралтай этгээд болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг удирдамжаа болгодог.

ТУЗ нь APU компанийн бизнесийн стратегийг тодорхойлох, хэрэгжилтийг нь хангуулах, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо үр дүнтэй ажиллах, санхүүгийн бүртгэл, тайлагналын тогтолцоо хуульд нийцсэн байх, Компанийн үйл ажиллагаа нь нийгмийн хариуцлагын зарчмыг даган мөрдөх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хамгаалагдсан байх зэрэг чиг үүргийг гүйцэтгэнэ.

ТУЗ нь APU компанийн бизнесийн стратеги болон тулгарч буй эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, санхүүгийн бүртгэл, тайлагналын тогтолцооны үйл ажиллагааг жилд хамгийн цөөндөө нэг удаа хянан хэлэлцэж, шаардлагатай шийдвэрүүдийг гарган ажилладаг.

ТУЗ доторх чиг үүргийн хуваарилалтыг ТУЗ-ийн үйл ажиллагааны холбогдох дүрэм журмаар тодорхойлсон бөгөөд эдгээр баримтыг Компанийн цахим хуудсанд байршуулсан.

ТУЗ-ийн гишүүдийг сонгох, улираан томилох, хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгох зэрэг шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргана. ТУЗ-ийг 3 жилээр томилох бөгөөд улиран томилох боломжтой.

ТУЗ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга хариуцдаг бөгөөд ТУЗ-ийн ажлын албын үйл ажиллагааг удирдан ажиллана. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь компанийн засаглалтай холбоотой асуудлыг шууд хариуцах эрх бүхий албан тушаалтан болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал 2016 онд 4 удаа хуралдсан бөгөөд хурлын ирц 88.6%-тай байсан.

БҮРЭЛДЭХҮҮН

ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 нь хараат бус гишүүн: Пүрэвийн Батсайхан (ТУЗ-ийн дарга), Пүрэвийн Батчимэг, Бүрэнтогтохын Батбаяр, Сергей Громов, Хьюго Барретт, Харон Хамхоев, Александр Сиваев (Хараат бус гишүүн), Жигжидийн Үнэнбат (Хараат бус гишүүн), Сосорбарамын Эрдэнэ (Хараат бус гишүүн).

Гишүүдийн мэргэжил, ажлын туршлага:



П.Батсайхан

Инженер мэргэжилтэй.
1993-1996 онд Шунхлай ХХК-ийн Ерөнхий захирал
1997-2008 онд Шунхлай групп ХХК-ийн Ерөнхий захирал
2002-2004 онд АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга
2004-2008 онд АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал
2008 оноос одоог хүртэл Шунхлай групп ХХК-ийн Ерөнхийлөгч,
APU компанийн ТУЗ-ийн дарга



П.Батчимэг

Багш мэргэжилтэй.
Орос хэлний багшийн дээд сургууль, Цагдаагийн академид багш,
ахлах багш, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яманд мэргэжилтэн.
2004-2007 онд АПУ импекс ХХК-ийн Ерөнхий захирал
2007 оноос одоог хүртэл
АПУ Трейдинг ХХК-ийн Ерөнхий захирал
2005 оноос одоог хүртэл АPU компанийн ТУЗ-ийн гишүүн



Б.Батбаяр

Эдийн засагч мэргэжилтэй.
1994-1996 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуульд багш
1999-2001 онд Эдийн засгийн бодлогыг дэмжих төслийн Арилжааны
банкны зөвлөх
2002-2012 онд Европын сэргээн босголт, хөгжлийн банканд Ахлах
мэргэжилтэн
2012 оноос одоог хүртэл Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал
2013 оноос одоог хүртэл АPU компанийн ТУЗ-ийн гишүүн



Ж.Үнэнбат

Эдийн засагч мэргэжилтэй.
1990-2000 онд Монголбанкинд эдийн засагч,
хэлтсийн дарга, Ерөнхийлөгч 1996-2000 онд
Азийн хөгжлийн банк, Монгол улсыг хариуцсан захирал
2000-2006 онд Монголын Банкны Холбооны Гүйцэтгэх захирал
2009-2015 онд Компанийн Засаглалын
Хөгжлийн Төвийн Гүйцэтгэх захирал
2015 оноос одоог хүртэл Монголын Банкны Холбооны Ерөнхий нарийн
бичгийн дарга
2013 оноос одоог хүртэл АPU компанийн ТУЗ-ийн гишүүн



С.Громов

Инженер мэргэжилтэй.
 1992-1994 онд ОХУ-ын "Разноимпорт" ХХК-д менежер
 1994-2000 онд "Транс-ворлд Аллюминум" компанийн Лондон дахь салбарын захирал
 2001 оноос одоог хүртэл Чингисхаан банкны ТУЗ-ийн дарга
 Монгол даатгал ХХК-ийн ТУЗ-ийн дарга
 2013 оноос одоог хүртэл АПУ компанийн ТУЗ-ийн гишүүн



Х.Барретт

Эдийн засагч мэргэжилтэй.
 1990-1992 онд Блю Доор Девелопментс ХХК-д менежер
 1992-1995 онд Транс-ворлд металз ХХК-д менежер
 1995 оноос одоог хүртэл Орион Ресурс ХХК-ийн захирал
 2013 оноос одоог хүртэл АПУ компанийн ТУЗ-ийн гишүүн



Х.Хамхоев

Инженер-эдийн засагч мэргэжилтэй.
 1990-1992 онд "Лион" ХХН-ийн орлогч захирал
 1992-1994 онд "БрАЗ" үйлдвэрийн
 Казахстан дахь төлөөлөгчийн газрын орлогч захирал
 1994-2000 онд "БрАЗ" үйлдвэрийн
 Бээжин дэх төлөөлөгчийн газрын орлогч захирал
 2000 оноос одоог хүртэл "Орион Интернэшнл" ХХК-ийн Ерөнхий захирал
 2015 оноос одоог хүртэл АПУ компанийн ТУЗ-ийн гишүүн



А.Сиваев

Эрх зүйч-эдийн засагчийн мэргэжилтэй.
 2001-2005 онд "Русский алюминий" компанийн охин компаниудад хэлтсийн дарга, санхүү хариуцсан захирал
 2005 оноос одоог хүртэл "Красный яр" ХХК-ийн санхүү хариуцсан захирал, Ерөнхий захирал
 2015 оноос одоог хүртэл АПУ компанийн ТУЗ-ийн гишүүн



С.Эрдэнэ

Хуульч мэргэжилтэй.
 1990-1993 онд Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газарт Төлөөлөгч
 1993-2000 онд Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэст Төлөөлөгч, Тасгийн дарга
 2000 оноос одоог хүртэл ЭДКС ХХК-ийн захирал, ТУЗ-ийн дарга
 2013 оноос одоог хүртэл Нарта ХХК-ийн ТУЗ-ийн дарга
 2014 оноос одоог хүртэл Нарта констракшн ХХК-ийн ТУЗ-ийн дарга
 2015 оноос одоог хүртэл АПУ компанийн ТУЗ-ийн гишүүн

ХОРООД

ТУЗ нь дэргэдээ Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороотой. Хороодын бүрэлдэхүүнийг дэлгэрэнгүй дурьдвал:

1. Аудитын хороо: Ж.Үнэнбат (хорооны дарга), Б.Батбаяр, С.Эрдэнэ.

Хорооны чиг үүрэг: Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн үйл ажиллагаа олон улсын стандартад нийцсэн байх явдлыг хангуулах, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагнал, санхүү, эдийн засгийн байдалд хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй.

2. Цалин урамшууллын хороо: С.Громов (хорооны дарга), С.Эрдэнэ, Ж.Үнэнбат.

Хорооны чиг үүрэг: Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг баталж хянах, ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах үндсэн чиг үүрэгтэй.

3. Нэр дэвшүүлэх хороо: П.Батсайхан (хорооны дарга), С.Эрдэнэ, А.Сиваев.

Хорооны чиг үүрэг: ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлох, тухайн шаардлагад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагыг сонгох, томилох ажлыг зохион байгуулах, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үндсэн чиг үүрэгтэй.

ЦАЛИН УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

Компанийн ерөнхий бодлого

APU компани нь өөрийн цалин урамшууллын тогтолцоондоо дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Зах зээлд өрсөлдөхүйц цалин урамшууллын тогтолцоогоор дамжуулан мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтнуудыг татан ажиллуулж, тогтвор суурьшилтай ажиллахад нь анхаарах;
- Ажилтан, ажиллагсдын зохистой карьерийн удирдлагыг хангах зорилгоор албан тушаал дэвшүүлэх, тасралтгүй суралцах нөхцөл боломж бүрдүүлэх, гадаад дотоодын сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх, сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох;
- Ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг бодитойгоор үнэлэн, гүйцэтгэлд тохирсон урамшуулал олгох;
- Ажилтнуудын нийгмийн тодорхой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор нийгмийн хөгжлийн сан бүрдүүлж, тэтгэмж, дэмжлэг олгох;
- Жил бүр цалин хөлсний судалгаа хийж, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал, макро эдийн засгийн төлөв, инфляцийн түвшинтэй уялдуулан цалин хөлсний түвшингээ нэмэгдүүлэх.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ШИЙДВЭР ГАРГАХ ПРОЦЕСС

APU компанийн ТУЗ-ийн ээлжит хурал улирал бүр хуралдах ба шаардлагатай бол ээлжит бус хурал болон эчнээ санал хураалтаар шийдвэр гаргана. Шийдвэрийг хуралд оролцсон гишүүд, эчнээ хураасан саналын дийлэнх олонхоор гаргана. Мөн түүнчлэн, Монгол Улсын Компанийн тухай хуульд зааснаар, их хэмжээний хэлцлийн тухайд зөвхөн санал нэгтгэйгээр шийдвэр гаргах (санал зөрсөн тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэх), ашиг сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухайд ийм сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүн саналаа түдгэлзүүлэх зэрэг зарчмуудыг баримтлан ажиллана.

Хурлаар шийдвэрлэх асуудалд санал оруулах, танилцуулах, шийдвэр гаргуулах процессийг ТУЗ-ийн үйл ажиллагааны дүрмээр нарийвчлан тодорхойлсон.

Ашиг сонирхлын зөрчилтэй этгээд, харилцан хамааралтай этгээдийн жагсаалтыг жил бүр шинэчилж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж зэрэг байгууллагуудад тайлагнадаг.

2016 оны байдлаар, дараах харилцан хамааралтай этгээдийг тодорхойлсон:

Хувьцаа эзэмшигчид

1. Туул Интернэшнл ХХК
2. Вит Альянс Лимитэд
3. Зеннор Интернэшнл ХХК
4. Голомт Банк ХХК

Охин компани

1. Гранд ХХК
2. Чингис Хаан Интернэшнл Лимитэд

Бусад харилцан хамааралтай компаниуд

1. АПУ Трейдинг ХХК
2. Депод ХХК
3. Шунхлай Трейдинг ХХК
4. Шунхлай ХХК
5. Шунхлай Групп ХХК
6. Хьюндай Моторс Монгол ХХК
7. Киа Моторс Монгол ХХК
8. Медиа Групп ХХК
9. Паблик Медиа ХХК
10. Амилан.Э ХХК
11. НТВ Бродкастинг ХХК
12. Жи Эс Би Майнинг ХХК
13. Пауер Юнит ХХК
14. Сантранс Логистикс ХХК
15. Сантранс ХХК
16. Интернэшнл Мэдикал Сентэр ХХК
17. Капитал Групп ХХК
18. УБ Спирт ХХК
19. Жи Эс Би Капитал ХХК
20. Скайтел ХХК
21. Натур Агро ХХК
22. Ван Трейд ХХК
23. Грийт Эмпайр ХХК
24. Скаймедиа Корпораци ХХК
25. Монгол Даатгал ХХК
26. Чингис хаан банк ХХК
27. Блю Скай Кашемир ХХК

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР

APU компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос 2014 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн №162 тоот тогтоолоор баталсан "Компанийн засаглалын кодекс"-ийн зарчим, үзэл баримтлалд компанийн үйл ажиллагааг үе шаттайгаар нийцүүлэх зорилгоор "Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр" боловсруулан Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс батлан хэрэгжүүлж байна.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд компанийн засаглалын дотоод журамд хамаарах бодлогын баримт бичгүүдийг тодорхойлсон бөгөөд хөтөлбөрийг хоёр үе шаттайгаар хэрэгжихээр тусгасан. Эхний үе шатанд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өмнө нь баталж, одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй бодлого, дүрэм журмыг багтааж, хоёрдугаар үе шатанд цаашид баталж мөрдүүлэх шаардлагатай бодлого, дүрэм журмын батлах хуваарийг тогтоосон.

Эхний үе шатын хүрээнд батлагдсан баримт бичгүүд:

1. Ногдол ашгийн бодлого
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргын дотоод журам
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны ажиллах журам
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны ажиллах журам
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны ажиллах журам
7. Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх дотоод журам
8. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам
9. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам

2016 онд APU компаниас баримтлах "Эрсдэлийн удирдлагын бодлого", "Дотоод аудитын бодлого" зэрэг баримт бичгүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлан гаргах эрх зүйн үндэсийг тавьсан.

Хоёрдугаар үе шатын хүрээнд 2017 онд батлагдах баримт бичгүүд:

1. Үнэт цаасны дотоод мэдээлэл эзэмшигчдийн үйл ажиллагааны тухай журам
2. Өргөдөл, гомдол хүлээж авах журам
3. Компанийн ёс зүйн дүрэм
4. Цалин урамшууллын бодлого
5. Залгамж халааны бодлого
6. Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр хуваарийн дагуу хэрэгжиж байна.

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

1992 онд Архи пиво комбинатаас Архи, пиво, ундаа буюу АПУ Хувьцаат компани болон 49 хувийг хувьчилж, 2001 онд үлдсэн 51 хувийг дуудлага худалдаанд оруулан өмчлөх эрхийг шилжүүлснээр 100 хувь хувьчлагдсан.

АПУ Компани нь 2005 онд Улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн авсан бөгөөд хууль эрх зүйн орчин шинэчлэгдэн сайжирснаар нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр Улсын бүртгэлд бүртгэгдсэн. Үүнээс хойш 3 жилийн дараа буюу 2008 онд АПУ Компани /Симбол АПУ/-ийн нэгж хувьцааны ханш 54,000 төгрөгт хүрч хувьцааны хөрвөх чадвар муудсанаар хувьцааг хуваах шийдвэр гарсан. Ингээд 2008 оны 7 сарын 15-нд нэгж хувьцааг 100 дахин хуваах шийдвэр гарч нэгж хувьцааны үнэ 540 төгрөгөөс 621 төгрөг хүртэл буюу 15%-иар өсч байсан түүхтэй.

2016 оны 4 сарын 22-ны өдөр хувьцааны хөрвөх чадварыг сайжруулах, зах зээлийн үнийг нэмэгдүүлэх, одоогийн хувьцаа эзэмшигчдийг илүү олон хувьцаатай болгох, хувьцааны арилжааг идэвхжүүлэх зорилгоор нэгж хувьцааг 10 дахин хуваах шийдвэр гаргаж нэгж хувьцааны зах зээлийн үнэ 397 төгрөгөөс 444 төгрөг хүртэл буюу 12%-иар өссөн.

2015 онтой харьцуулахад 2016 оны АПУ компанийн жигнэсэн дундаж хаалтын ханш 374 буюу 5 хувийн өсөлттэй байна.



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

APU компани нь 2005 онд хувьчлагдсанаас хойш ногдол ашгийн бодлогыг хэрэгжүүлж хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгийг зохистой түвшинд байлгах бодлого баримтлан ажиллаж байна. Ногдол ашгийг хуваарилах шийдвэр нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх үндсэн үзүүлэлтийн нэг юм.

	Ногдол ашиг тараасан хувьцаа	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг	Нийт ногдол ашиг / сая.төг/	Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн %
2005 он	742,877	130	97	
2006 он	742,877	60	45	
2007 он	742,877	538	400	2.80%
2008 он	74,287,700	10	743	2.30%
2009 он	74,167,019	20	1,483	3.20%
2010 он	74,167,019	40	2,967	2.00%
2011 он	74,167,019	60	4,450	1.40%
2012 он	74,167,019	70	5,192	1.80%
2013 он	74,167,019	90	6,675	2.20%
2014 он	74,167,019	0	-	
2015 он	74,167,019	70	5,192	1.80%
2016 он	741,670,190	1	742	0.25%

Дундаж /ногдол ашгийн хувь/ 1.97%

APU компанийн хувьд хувьцаа эзэмшигчиддээ 2005 оноос одоог хүртэл ногдол ашгийг тасралтгүй тарааж ирсэн бөгөөд "Нэгж хувьцаанд тогтмол ногдуулах" ногдол ашгийн бодлого барьж ирсэн.

Өнгөрсөн хугацаанд APU компанийн олгож байсан ногдол ашгийн дундаж хэмжээг тооцвол олон улсын шингэн хүнсний томоохон компаниудын дундаж үзүүлэлт болох 1.9%-тэй ойролцоо түвшинд байна.

	Dividend Yield %
Anheuser-Busch Inbev SA	3.22%
HEINEKEN (NV)	1.49%
SABMiller PLC (BRW1.DE)	1.6%
Carlsberg B	1.46%

Эх сурвалж: Dividend ranking & finance.yahoo.com

УДИРДЛАГЫН БАГ

УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гүйцэтгэх захирлын дэргэд, түүнийг шийдвэр гаргахад зөвлөх, чиг үүрэг хариуцсан Захирлуудын зөвлөл ажилладаг. Захирлын зөвлөлийг Гүйцэтгэх захирал даргалах бөгөөд Үйлдвэрлэл үйл ажиллагаа хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирал, Захиргаа хүний нөөц хариуцсан захирал, Төсөл хариуцсан захирал, Харилцаа инноваци хариуцсан захирал гэсэн 6 гишүүдийн бүрэлдэхүүнтэй.



**ЦЭВЭЭНЖАВ
ЭРДЭНЭБИЛЭГ**
Гүйцэтгэх захирал



**АРИУНАА
ДАНДАРОВА**
Харилцаа, Инноваци
хариуцсан захирал



**БАНЗРАГЧ
ТҮВШИН**
Санхүү хариуцсан захирал



**ГОНЧИГ
ЭНХБИЛЭГ**
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа
хариуцсан захирал



**АВИРМЭД
МЭНДБАЯР**
Төсөл хариуцсан захирал



**БАДРУУГАН
НАРАНЗУН**
Захиргаа, Хүний нөөц
хариуцсан захирал

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

APU компани нь үйл ажиллагаагаа Компанийн засаглалын кодексын зарчим, үзэл баримтлалд нийцүүлж, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор компанийн засаглалыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд Эрсдэлийн удирдлага, Дотоод хяналт, Дотоод аудитын цогц бодлогыг тасралтгүй сайжруулахаар зорьж байгаа билээ.

Risk Profile /Эрсдэлийн профиль/

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь хүний эрүүл, мэнд аюулгүй байдалтай шууд холбогддог учраас тухайн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа компани бүр бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг өндөр түвшинд хангаж, стандарт, хууль дүрмийг чанд мөрдөн ажиллах зайлшгүй шаардлагатай. Манай компани ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцоо, ISO 14001 Байгаль орчны удирдлагын тогтолцоо болон FSSC 22000 Хүнсний аюулгүй байдлын тогтолцооны баталгаажуулалтын стандартуудыг хамтад нь нэвтрүүлсэн Монголын анхны компани болсноороо энэ үүргээ амжилттай биелүүлэн ажиллаж байгаа, салбартаа тэргүүлэгч, үндэсний манлай үйлдвэр юм.

Өнөө үеийн бизнесийн шинэ орчинд компаниуд шинэ төрлийн эрсдэлийг тодорхойлж, үнэлэн түүнээс үүсэх үр дагавараас урьдчилан сэргийлэх, зайлсхийх арга замуудыг эрчимтэй эрэлхийлж эрсдэлийг удирдаж байгаа.

Дээр дурдсанчлан дан ганц бидний үйл ажиллагаанаас үл хамааран хувьсан өөрчлөгдөж байгаа гадаад орчин, нөхцлөөс шалтгаалж олон төрлийн эрсдлүүд үүсч энэ нь манай компанид төдийгүй салбарын бусад компаниудад ч тодорхой нөлөөллийг бий болгосноор гадаад эх үүсвэрээс үүдэлтэй эрсдэлийн нөлөөллийг нэмэгдүүлж байна. Ингэснээр манай компани болоод салбарын бусад компаниудын ашигт байдал буурч байгаа нь санхүүгийн эрсдэл үүсэх шалтгаануудын нэг болж байна.

Risk mitigation /Эрсдэлийг сулруулах/

APU Компанийн хувьд эрсдэлийг үнэлэхдээ зөвхөн үүссэн эрсдэлийг үнэлэх биш түүний эх үүсвэр, учир шалтгааныг судалж, цаашид ямар үр дагавар гарч болох, компанийн аль түвшинд ямар зэрэглэлийн нөлөөлөл учруулахыг тооцоолсоноор эрсдэлийн цогц үнэлгээг сайжруулахаар ажиллаж байна. Ингэснээр тухайн эрсдэлд тохирох, оновчтой арга замуудыг сонгон хэрэгжүүлэх замаар эрсдэлийн үр дагаварыг бууруулж, удирдан ажиллаж байна.

Эрсдэлийн зураглал



2017 ОНЫ ӨНДӨР ЭРСДЭЛҮҮД

Засгийн газрын бодлогын өөрчлөлт

/Татварын өсөлт/

Тодорхойлолт: 2016 оны сонгуулийн үр дүнд нэг нам давамгайлсан УИХ бүрэлдэж, “Мэргэжлийн” тодотголтой ЗГ шинээр байгуулагдсан билээ. Засгийн газраас Монголд төсвийн хүндрэл, төлбөрийн тэнцлийн хүндрэл гэсэн хосолсон хүндрэл байгаа тул Олон Улсын Валютын Сан /ОУВС/ -ын хөтөлбөрт хамрагдах нь зүйтэй гэж үзэж байгаагаа мэдэгдсэн билээ. Хөтөлбөрийн хүрээнд төсвийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд хэд хэдэн арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ба тэр дундаа нийгмийн даатгалын сангийн шимтгэл болон онцгой албан татварын хувь хэмжээг шатлалтайгаар нэмхээр байгаа юм.

Боломжит нөлөөлөл: Засгийн газрын бодлогын өөрчлөлт үүн дотроо татварын өсөлт, Онцгой албан татварын хувь хэмжээний өсөлт нь компанийн татварын зардлыг нэмэгдүүлж, цаашлаад борлуулалтын цэвэр орлогыг бууруулах үндсэн нөхцөл болж байгаа ба зөвхөн манай компани төдийгүй салбарын нийт үйлдвэрүүдэд хүчтэй нөлөө үзүүлж байгаа өндөр зэрэглэлийн эрсдэл болох юм.

Эрсдэлийг сулруулах: Энэ төрлийн гадаад эх үүсвэрээс бий болсон эрсдэлүүдийн хувьд компанийн зүгээс ямар нэг хариу арга хэмжээ авах нь ихээхэн хүндрэлтэй бөгөөд нэг эх үүсвэрээс шалтгаалсан олон төрлийн салбарласан эрсдэл нэмж үүсэхээс зайлсхийж үйл ажиллагааныхаа зардлыг бууруулах, хууль, дүрэм, журмын нийцлийг хангах, салбарын хувьд үнийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх зэргээр үр дагаврыг бууруулж ажиллахыг зорьж байна.

Валютын ханшийн өсөлт

Тодорхойлолт: Төгрөг гадаад валютын эсрэг өндөр хувиар суларч 2015 онтой харьцуулахад 2016 онд ам долларын дундаж ханш 9%, хамгийн ихдээ 24%-р төгрөгийн эсрэг чангарсан үзүүлэлттэй байгаа юм.

Боломжит нөлөөлөл: Валютын тасралтгүй өсөлт нь компанийн түүхий эд материалын зардлыг нэмэгдүүлэх, валютын зээлийн төгрөгөөр илэрхийлэгдэх дүн нэмэгдэх зэргээр компанийн санхүүгийн байдалд шууд нөлөөлж байгаа өндөр зэрэглэлийн эрсдэл хэвээр байгаа.

Эрсдэлийг сулруулах: Ханшийн өсөлт, түүнээс үүсэх үр дагаврыг бууруулах зорилгоор бид валютын ханшийн хэлбэлзэл, трендийг судалж төгрөгийн эсрэг хэлбэлзэл багатай валютаар худалдан авалт хийхээр зорин ажиллаж байна. Үүний зэрэгцээ санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн хэрэглээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг эрмэлзэж байна.

Эдийн засгийн удаашрал

Тодорхойлолт: Эдийн засгийн өсөлтийн удаашралтай холбоотой ажилгүйдэл өсөн нэмэгдэж, өрхүүдийн мөнгөн орлого буурсан ба цаашид эдийн засгийн байдал энэ хэвээр үргэлжилбэл өрхийн орлого төдий л нэмэгдэхгүй бөгөөд үүнийг дагаад өрхийн хүнсний болон хүнсний бус хэрэглээний зарцуулалт буурч байгаа билээ. Статистик мэдээллээс харахад 2015 оны өрхийн дундаж зарлагад эзлэх хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний зарцуулалт өмнө оноосоо харгалзан 10, 11 хувиар тус тус буусан байна.

Боломжит нөлөөлөл: Өрхийн хүнсний хэрэглээ буурч байгаа нь компанийн борлуулалтын тоо хэмжээ буурах үндсэн нөхцөлүүдийн нэг болж байгаа.

Эрсдэлийг сулруулах: АПУ компанийн хувьд бүтээгдэхүүнийг зохион бүтээхээс эхлээд эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн түгээлтэд гаргах хүртэлх бүхий л процесст чанар стандартыг өндөр түвшинд ханган ажилладаг ба зөвхөн хэрэглээний тоо хэмжээний өсөлт рүү чиглэсэн бус хэрэглэгчдийнхээ хүсэл сонирхолд нийцсэн, чанарыг эрхэмлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэн ажиллаж байна.

ТОГТВОРТОЙ БАЙДАЛ



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

APU компанийн баримталж буй бодлого, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа үргэлж нийгэм, эдийн засагт үнэ цэнэ, баялаг бүтээхэд чиглэж, "Тогтвортой Хөгжил"-н үндсэн суурь зарчим болох ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧНЫ тэнцвэртэй хөгжлийг ханган, урт хугацаанд үр ашигтай ажиллахыг зорилго болгосоор ирсэн билээ.

ЭДИЙН ЗАСАГ

- Оролцогч талуудад үр ашгийг хүртээмжтэй байдлыг хүргэх
- Бүтээмжийг дээшлүүлэх замаар үр ашгийг нэмэгдүүлэх, баялаг бүтээх
- Үндэсний үйлдвэрлэгч
- Зардлыг бууруулах замаар үр ашгийг нэмэгдүүлэх

БАЙГАЛЬ ОРЧИН

- Байгаль орчны талаархи Монгол улсын хууль тогтоомж, үндэсний болон олон улсын стандартыг мөрдөх
- Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулах
- Орчны бохирдол, хог хаягдлыг бууруулна, дахин ашиглахад анхаарах
- Эрчим хүчийг хэмнэх
- Үйл ажиллагаандаа байнгын сайжруулалт хийж, хувьцаа эзэмшигч, хэрэглэгч, харилцагч, ажилтнуудтай шударга, нээлттэй хамтран ажиллах

НИЙГЭМ

- Хүнсний аюулгүй байдал, түүний чанар, стандартыг дээд зэргээр ханган ажиллах
- Үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, хүний хөгжил, байгаль экологид ээлтэй үйлдвэрлэлийг дэмжих үйлсэд хувь нэмрээ оруулах
- Шударга, ил тод өрсөлдөөний зарчимд тулгуурлан ажиллах
- Зохистой хэрэглээг дэмжин ажиллах
- Хэрэглээний боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах
- Хууль эрх зүй, ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн ажиллах
- Үл ялгаварлал, шударга байдлыг эрхэмлэх

ЭДИЙН ЗАСАГТ ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- APU компани нь 2016 онд Монгол улсын нэгдсэн төсвийн орлогод 127 тэрбум төгрөгийн татварыг төвлөрүүлэн ажиллаа.
- Хэдийгээр 2016 онд эдийн засгийн удаашрал үргэлжилж, төгрөгийн ханш их хэмжээгээр суларсан нь компанийн цэвэр ашигт сөргөөр нөлөөлсөн боловч 2017 онд 742 сая төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн.
- 2016 оны 4 сарын 22-ны өдөр одоогийн хувьцаа эзэмшигчдийг илүү олон хувьцаатай болгох, мөн хөрөнгийн зах зээл дэх хувьцааны арилжааг идэвхжүүлэх, хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор нэгж хувьцааг 10 дахин хуваах шийдвэр гарган хэрэгжүүлсэн.

БАЙГАЛЬ ОРЧИНД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бид өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болох нөлөөллийг ямагт анхааран нэн тэргүүнд байгаль орчинд ээлтэй техник, технологи, стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх замаар байгальд ээлтэйгээр үйлдвэрлэл явуулахыг эрхэмлэдэг. Компанийн байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг боломжит бага түвшинд хүргэх явдал нь ажилчин нэг бүрийн хариуцлага юм. 2016 онд бид байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулах үндсэн чиглэлийн хүрээнд дараах хэмнэлтүүдийг хийж ажилласан байна.

Эрчим хүчний хэмнэлт

Азийн бүтээмжийн байгууллагын зорилтот гишүүн орнуудад эрчим хүчний хэмнэлт сэдвээр загвар байгууллага болох төслийн 2015-2016 оны сонгон шалгаруулалтад Монгол улсаас 7 компани өрсөлдсөнөөс АПУ компани энэхүү төсөлд оролцох эрх авсан юм. Түүний дагуу эрчим хүчний хэмнэлтийн төслийг 2015-2017 оны хооронд хэрэгжүүлж уур, ус, дулаан, цахилгааны эрчим хүчийг хэмнэх, эрчим хүчийг сэргээн дахин ашиглах зорилтуудыг амжилттай хэрэгжүүлснээр АПУ Компани ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ АЗИЙН ЗАГВАР БАЙГУУЛЛАГА боллоо.

Усны хэмнэлт

Үйлдвэрлэлийн процессын үйл ажиллагаанаас гарсан хаягдал усыг дахин ашиглаж, улмаар барилга, зам талбай болон ногоон байгууламжийг услахад ашиглаж, нийт 11,544 м3 цэвэр усыг хэмнэж ажилласан.

Уур, дулааны хөргөлт

Уурын эрчим хүчний хувирсан усыг ашиглан, үйлдвэрийн барилга болон агуулахын барилгуудыг дулаанаар хангаж, дулааны эрчим хүчийг 14.5% хэмнэж ажилласан.

НИЙГЭМ БА ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улс орны хөгжлийн гол хүчин зүйл нь хүний хөгжил бөгөөд энэ ч утгаараа улс үндэстнийхээ нэр төрийг олон улсад таниулж байдаг урлаг спортынхон, мөн улс орны ирээдүй болсон хүүхэд залуусын мэдлэг боловсролд, Монголчууд бидний язгуур эрх ашиг болох ёс уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, хүн бүрт таниулах үйлсэд бид бодитойгоор хөрөнгө оруулалт хийж, олон төсөл хөтөлбөрүүдийн санаачлагч байдлаар зарим үйл ажиллагаанд оролцогч байдлаар нэгдэж хамтран ажиллаж байна. Ингэхдээ зөвхөн олон нийтэд төдийгүй ажилчидруугаа чиглэсэн үйл ажиллагааг хамт хэрэгжүүлж ирсэн билээ.

Ажилчиддаа чиглэсэн

- Эерэг хандлагыг түгээх, дэлгэрүүлэх, сурталчлах үйлсэд хувь нэмрээ оруулах
- Шинэ санал, санаачлагыг дэмжих
- Төгөлдөр Төслийн хүрээнд үндэсний өв соёл, зан заншлыг таниулах, мэдлэг олгох, дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- Мэдээллийн урсгалыг сайжруулах

Олон нийт рүү чиглэсэн

- Хүүхэд залууст чиглэсэн олон төрлийн үйл ажиллагааг Төрийн болон Төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах
- Үндэсний өв соёл, зан заншлаа таниулах, мэдлэг олгох үйлсэд хувь нэмрээ оруулах
- Залуу үеийнхнийг спорт, биеийн тамираар хичээллэх, ОУ-ын тэмцээн уралдаанд оролцох, амжилт гаргахад дэмжих

ХҮНИЙ НӨӨЦ, ХӨГЖИЛ

Мөрөөдлөө биелүүлэхэд хормоор хэмжигдэж буй их хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн алхах, сайхан ирээдүйг хамтдаа босгох, эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах алтан боломжийг хүн бүрийн өмнө нээлттэй байлгахын төлөө АПУ компани ажилладаг.

Монгол төдийгүй олон улсын түвшинд үнэлэгдсэн хүнсний манлай үйлдвэрлэгч, найдвартай ажил олгогч, дэлхийн шилдэг технологи, шийдлийг нэвтрүүлэгч АПУ компани-д ажилласнаар өсөн дэвших, өөрийгөө хөгжүүлэх олон боломжийг өмнөө нээж өрсөлдөхүйц, цалин урамшуулал, аюулгүй тохилог орчинд чадварлаг, эвсэг, бүтээлч хамт олны нэгэн хэсэг болон ажиллах боломжтой. Ажил хөдөлмөрөөрөө гаргасан амжилт, бүтээсэн үйлсдээ сэтгэл хангалуун байж, ирээдүйн төлөө хөгжлийн зүг хамтдаа алхахад АПУ компанийн ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ЗОРИЛГО оршино.

АПУ компани нь 2016 онд ажилтнуудынхаа хувь хүний хөгжилрүү чиглэсэн “Сайн хандлага, Сайн харилцаа, Сайн хүн ” концепцийн дагуу төлөвлөгөө боловсруулан ажилласан ба АПУ компани нь хүний нөөцийн хөгжлийн хүрээнд хувь хүний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн 392 мэргэжлийн болон ажлын байрны сургалтуудыг амжилттай зохион байгуулсан. Үүнд:

- Топ менежерүүдээ - “Нөхцөл байдалд тулгуурласан манлайлал” сургалтанд хамруулсан.
- Инженер, менежерүүддээ - “Сайн хандлага, Сайн харилцаа, Сайн хүн” сургалтыг дунд түвшний менежерүүдэд амжилттай зохион байгуулсан.
- Ажилтан бүрийн хувь хүний хөгжил манлайллыг хөгжүүлэх замаар сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, компанийн үнэ цэнэ өсгөх зорилготойгоор “ТӨГӨЛДӨР ТӨСӨЛ” үргэлжилж байгаа

Дээрх ажлын үр дүнг ажилчдаас авсан соёлын судалгаанаас харахад 2016 онд шинэ санаа, бүтээлч хандлага: 5.2%, ажлын төлөвлөлт: 4.5%, харилцаа холбоо, ажлын уялдаа: 4.1% болж өнгөрсөн оныхоос тус тус өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Мөн бид Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан гэрээгээ 100% биелүүлж, ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 1,495,504,662 төгрөгийг зарцууллаа.

- Тэтгэвэр, тэтгэмж 33,681,159 төгрөг
- Дэмжлэг тусалцаа 49,297,405 төгрөг
- Шагнал урамшуулал 72,427,840 төгрөг
- Өдрийн хоол, эрүүл мэндийн үйлчилгээнд 1,340,098,258 төгрөгийн тусламж үзүүлсэн.

ХӨДӨЛМӨР АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

- Ажилтнуудын ая тухтай ажил амралтыг зохицуулан хоолны газрыг тохижуулан илчлэг сайтай хоолоор үнэгүй тогтмол үйлчилж байна.
- Онцгой нөхцөлд ажилладаг ажилтнуудад өдөр бүр сүү, тараг, өвлийн улиралд аарц олгодог.

Зөвхөн ажилчиддаа үйлчилдэг АПУ эмнэлэгтэй бөгөөд эмнэлэг нь яаралтай болон анхан шатны тусламжийг үзүүлэх, ажлын байрнаас хөндийрүүлэлгүй эмчлэн эрүүлжүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх болон амьдралын зөв дадал, хэв маяг олгохтой холбоотой нийгэм эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг.

ТӨГӨЛДӨР ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БИД

Төгөлдөр төслийн үр дүнд хамт олны эв нэгдэл, үйлдвэр, алба нэгжийн хоорондын уялдаа холбоо илүү сайжирч, улмаар ажлын төлөвлөлтийг үр дүнтэй зохион байгуулах, шинэ санаа бүтээлч хандлагыг дэмжих, харилцан суралцаж, туршлага солилцох боломжийг бүрдүүлэхэд компанийн зүгээс ихээхэн анхаарч ажиллалаа.

Гэр бүлийн аялал

Компанийн ажилчдын гэр бүлийн гишүүдэд компанийн үйл ажиллагааг танилцуулах, сурталчлах зорилготой 2015 оноос хэрэгжүүлж байгаа уг үйл ажиллагааг үргэлжлүүлэв.



APU олимп

APU компанийн тамирчин РИО-ын хүрэл медальт Д.Отгондалайд хүндэтгэл үзүүлэх зорилгоор мөн хамт олны уур амьсгалыг бэхжүүлж, нэгдмэл байдлыг хадгалах, спортоор дамжуулан нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилготой АPU олимпыг уламжлал ёсоор амжилттай зохион байгуулсан



Амжилт ба Хандлага сургалт

Сургалтыг мэргэжлийн багш нар орсон бөгөөд ажлын байран дээр эерэг хандлагыг бий болгож, өөрийнхөө амжилтыг ахиулахад ашиглаж болохуйц олон саналыг дэвшүүлсэн, хүмүүсийн оролцоог дэмжсэн сонирхолтой үйл ажиллагаа болсон юм.



Нэг цэгийн үйлчилгээ

Нийт ажилчдад зориулан захиргааны алба нэгжүүдээс төрийн байгууллагууд, харилцагч банкуудтай хамтран нэг дор олон төрлийн зөвөлгөө, зааварчилгаа өгч, ажилчдыг мэдээллээр ханган ажилласан бөгөөд ажилчдын дунд түгээмэл гардаг асуултуудад хариулт өгсөн чухал арга хэмжээ болсон юм.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД БИД

APU компани нь улс орныхоо өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлан Нийгмийн хариуцлагын цогц бодлогыг системтэйгээр явуулж, “Тогтвортой Хөгжил”-ийг хангах зорилгоор БАЙГАЛЬ ЭКОЛОГИ, ХҮНИЙ ХӨГЖИЛ, ӨВ СОЁЛ гэсэн чиглэлүүдэд ёс зүйгээ баримтлан, бодитойгоор хөрөнгө оруулалт хийх замаар олон нийт болон ажилчдадаа хандсан үр дүнтэй төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

БАЙГАЛЬ ЭКОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР

“Тунгалаг туул аян-2016”

Байгальд ээлтэй үйлдвэрлэлийг дэмжих, бусад үйлдвэр аж ахуй нэгж, ард иргэдийг Туул голоо тунгалаг байлгая уриан дор нэгдэхийг уриалах зорилтын хүрээнд “Тунгалаг туул аян” 2 дахь жилдээ зохион байгуулж Туул голын эрэг дагуух 28 га газрын цэвэрлэгээнд компанийн нийт 300 ажилтан хамрагдсан



“Нэг өрх-Нэг мод”

Ногоон Монголын төлөө нэгдэе уриан дор “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан ажилчдыг 2 өдрийн сургалтанд хамруулж өрх бүрийг моджуулах аяныг хэрэгжүүлсэн. Компанийн нийт 250 ажилтан хамрагдаж, хүн бүр 5-10 мод тарьсан байна. “Дээлтэй Монгол” арга хэмжээнд нэгдэв



Ус чандмань эрдэнэ

Уг арга хэмжээний үр дүнд “Саарал” усанд шинжилгээ хийж, улмаар Нийслэл хотын цэцэгжүүлэлт болон бусад байдлаар ашиглахаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, “Саарал” усыг дахин ашиглахад бэлэн болоод байна.



ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Өсвөрийн шатрын аварга шалгаруулах “Азийн аварга” наадмыг дэмжив

Хувь хүний хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд оюуны хөгжлийг дэмжих байгууллагаар ажилласан юм. 2000 хүүхэд оролцсон уг тэмцээнийг “Маамуу” брэндээрээ ивээн тэтгэж оролцов.



Авто ослоос урьдчилан сэргийлэх цуврал “видео” хийлгэв.

Авто ослоос урьдчилан сэргийлэх, олон нийтийн дунд сэрэмжлүүлгийг хүргэх зорилгоор Замын Цагдаагийн Албатай хамтран 3 төрлийн видео шторкыг бэлтгэж олон нийтийн сүлжээ болон телевизүүдээр цацаж хүргэсэн билээ.



ФС Улаанбаатар хөл бөмбөгийн багтай хамтран ажиллаа.

APU компани нь 2016 оноос эхлэн ФС Улаанбаатар хөл бөмбөгийн багтай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг үзэглэсний дагуу дэмжин ажиллаа.



“Эерэг хандлага” сургалт

“Positive Mind” буюу Эерэг Хандлага түгээх сургалтыг Олон улсын JCI байгууллагатай хамтран гадаад дотоодын оюутан сурагчдад танилцуулах үйлсэд APU компани нэгдэн ажилласан юм.



Олимпын хүрэл медальт, тамирчин Д.Отгондалайг шагнаж урамшуулав.

APU компанийн хувьд бокс, буудлагын спортуудыг дэмжиж ирсэн бөгөөд энэ ч утгаараа манай компанийн тамирчин ОУХМ, Азийн наадмын аварга, Азийн наадмын алтан медальт, Олимпын хүрэл медальт Д.Отгондалай уйгагүй бэлтгэл сургуулилтын үр дүнд “РИО 2016” зуны XXXI дэх наадамд амжилттай оролцож хүрэл медаль хүртлээ.



ӨВ СОЁЛЫН ЧИГЛЭЛЭЭР

“Дээлтэй Монгол” арга хэмжээ

Өв соёлоо дээдлэх түүнийг түгээн дэлгэрүүлэх зорилтын хүрээнд Дээлтэй Монгол өдөрлөгт оролцсон.

Уг өдөрлөгт олон улсын зочид төлөөлөгчид болон 2500 ард иргэд үзэж сонирхдог бөгөөд тус үйл ажиллагаанд компанийн 39 ажилчин баярын жагсаалд нэгдэж, Монголынхоо ард иргэдэд мэндчилгээ дэвшүүлсэн юм.



Морин хуурын олон улсын V наадам

Морин хуур хөгжмөөр дамжуулан Монголын үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг дэмжин Морин хуурын олон улсын "V" наадмын ивээн тэтгэгчээр оролцлоо.



“Дэлхийн сүүний өдөр”-т нэгдэв

Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хувьд өөрсдийн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд танилцуулж, амталгаат худалдаа, урамшуулал, парад зэрэг үйл ажиллагаа зохион байгуулагдаж АРУ компани оролцов.



Илгээлтийн эзэдтэй хамт

Нийгмийн эмзэг давхаргын 50 эмэгтэйн үйл ажиллагааг дэмжин хурга ишигний 500 нэмнээг захиалгаар хийлгэж, өвөлжилт хүндэрч байгаа сумдад илгээлтийн эздээр дамжуулан хүргүүлсэн.



ШАГНАЛ



ТОП-100 АЖ АХУЙ НЭГЖ
Монголын Үндэсний Худалдаа
Аж Үйлдвэрийн Танхим



**ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ
АЗИЙН ЗАГВАР БАЙГУУЛЛАГА**
Азийн бүтээмжийн байгууллага



ҮНДЭСНИЙ ШИЛДЭГ ТАЙЛАН /ARAM/
Компанийн засаглалын хөгжлийн төв, Санхүүгийн
зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо болон Монголын
хөрөнгийн бирж



WORLD VODKA AWARDS-2016
Соёмбо, Arkhi, Улаанбаатар



**CATHAY PACIFIC HONG KONG
INTERNATIONAL /WINE & SPIRIT COMPETITION/**
Arkhi Export Limited Edition Vodka /Gold Winner/
Chinggis Khan Vodka /Silver Winner/



ALUFOIL TROPHY-2016
Ил нууцлал бүхий ТЕ системийн бөглөө олон
улсын тэмцээнээс шинэ, шилдэг шийдэл бүхий
бөглөөгөөр шалгарав

САНХҮҮГИЙН ТАЙЛАН



САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ		2016	2015
ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө	сая.төг	189,332.59	208,295.14
Биет бус хөрөнгө	сая.төг	553.66	645.07
Биологийн хөрөнгө	сая.төг	82.95	102.99
Урт хугацаат хөрөнгө оруулалт	сая.төг	904.84	904.84
Хойшлогдсон татварын хөрөнгө	сая.төг	10,229.98	6,304.57
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	сая.төг	201,104.02	216,252.61
Бараа материал	сая.төг	51,651.06	56,251.09
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	сая.төг	5,218.46	5,280.31
ОАТ-н авлага	сая.төг	42.44	1,068.07
Бусад авлага	сая.төг	16,383.32	20,023.75
Бусад санхүүгийн хөрөнгө	сая.төг	33.81	33.81
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	сая.төг	16,636.67	6,762.57
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	сая.төг	89,965.77	89,419.60
НИЙТ ХӨРӨНГӨ	сая.төг	291,069.79	305,672.21
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувьцаат капитал	сая.төг	74.17	74.17
Дахин үнэлгээний нөөц	сая.төг	80,653.25	80,694.98
Хуримтлагдсан ашиг	сая.төг	62,458.06	64,725.34
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ	сая.төг	143,185.47	145,494.49
ӨР ТӨЛБӨР			
Урт хугацаат зээл	сая.төг	70,117.59	88,080.21
Хойшлогдсон татварын өр	сая.төг	244.27	254.44
Бусад өглөг	сая.төг	195.43	1,938.26
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	сая.төг	70,557.29	90,272.91
Богино хугацаат зээл w	сая.төг	39,742.39	31,863.45
Бусад өглөг	сая.төг	37,584.63	38,041.37
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	сая.төг	77,327.02	69,904.82
НИЙТ ӨР ТӨЛБӨР	сая.төг	147,884.31	160,177.72
ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ	сая.төг	291,069.79	305,672.21

ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ		2016	2015
Борлуулалтын орлого	сая.төг	208,055.31	210,111.18
Борлуулалтын өртөг	сая.төг	(142,012.62)	(146,597.51)
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)	сая.төг	66,042.69	63,513.67
Удирдлага, борлуулалтын зардал	сая.төг	(29,848.66)	(27,845.16)
Бусад орлого	сая.төг	1,101.37	1,311.42
Бусад зардал	сая.төг	(1,143.21)	(2,776.27)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ	сая.төг	36,152.20	34,203.66
Санхүүгийн орлого	сая.төг	7,652.28	3,648.76
Санхүүгийн зардал	сая.төг	(40,048.26)	(19,805.58)
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)	сая.төг	3,756.21	18,046.84
Орлогын татварын зардал	сая.төг	(873.53)	(7,376.67)
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ (АЛДАГДАЛ)	сая.төг	2,882.68	10,670.17
Хөрөнгийн үнэлгээний нэмэгдэл	сая.төг	-	-
ТАЙЛАНТ ҮЕИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО	сая.төг	2,882.68	10,670.17

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ		ӨМЧ	ХАЛААСНЫ ХУВЬЦАА	ХУРИМТЛАГДСАН АШИГ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	НИЙТ ДҮН
2014	сая.төг	74.29	(0.12)	81,032.44	53,717.71	134,824.32
				-		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	сая.төг	-	-	-	10,670.17	10,670.17
Өмчид гарсан өөрчлөлт	сая.төг	-	-	(337.46)	337.46	-
2015	сая.төг	74.29	(0.12)	80,694.98	64,725.34	145,494.49
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	сая.төг	-	-	-	2,882.68	2,882.68
Зарласан ногдол ашиг	сая.төг	-	-	-	(5,191.69)	(5,191.69)
Өмчид гаргасан өөрчлөлт	сая.төг	-	-	(41.74)	41.74	-
2016	сая.төг	74.29	(0.12)	80,653.25	62,458.07	143,185.49

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ		2016	2015
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Цэвэр ашиг	сая.төг	2,882.68	10,670.17
Тохируулах бичилт	сая.төг	53,397.18	45,680.03
Ажлын капиталын өөрчлөлт	сая.төг	1,168.68	(3,515.42)
Төлсөн зээлийн хүү	сая.төг	(5,981.20)	(6,795.79)
Хүлээн авсан хүүгийн орлого	сая.төг	170.30	91.51
Төлсөн орлогын албан татвар	сая.төг	(3,880.38)	(5,822.70)
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	сая.төг	47,757.26	40,307.81
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Үндсэн хөрөнгө худалдаж авсан	сая.төг	(2,904.41)	(5,021.39)
Биет бус хөрөнгө худалдаж авсан	сая.төг	(72.46)	-
Үндсэн хөрөнгө худалдсан	сая.төг	12.25	355.15
Биологийн хөрөнгийн өөрчлөлт	сая.төг	-	(22.47)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	сая.төг	(2,964.63)	(4,688.71)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Төлсөн зээл	сая.төг	(34,755.50)	(38,861.30)
Төлсөн ногдол ашиг	сая.төг	(376.79)	(0.62)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	сая.төг	(35,132.30)	(38,861.92)
БУХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	сая.төг	9,660.34	(3,242.82)
ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	сая.төг	6,762.57	9,946.98
Гадаад валютын ханшийн хэлбэлзлийн нөлөө	сая.төг	213.76	58.41
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	сая.төг	16,636.67	6,762.57

1. ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

Тайлагналын нийцэл

Тусдаа санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу, Монгол улсын хууль тогтоомж, түүний нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актын хүрээнд бэлтгэсэн. Тайланг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт ("НББОУС") 27 буюу "Тусдаа Санхүүгийн Тайлан" хэмээх стандартын дагуу бэлтгэсэн.

Үнэлгээний суурь

Энэхүү тусдаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад өөрөөр тодруулсанаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн, бүх тайлант үе бүрт уг бодлогуудыг тууштай хэрэгжүүлсэн болно.

Бүртгэлийн болон толилуулгын валют

Тусдаа санхүүгийн тайланг компанийн бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагаа явуулж буй анхдагч эдийн засгийн орчны үндсэн валют болно.

Таамаглал, тооцоолол болон үнэлэмжийн хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно. Удирдлага эдгээр тооцоолол болон түүнд хэрэглэсэн таамаглалыг байнга хянаж байдаг.

2.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

ГАДААД ВАЛЮТААРХ АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн зүйлсийг балансын өдрийн хаалтын ханшаар төгрөг рүү хөрвүүлэн илэрхийлдэг. Бодит үнэ цэнээр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийн зүйлсийг тухайн бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлдэг. Түүхэн өртгөөр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар тайлагнадаг.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Компани нь зээл болон авлагыг анх үүссэн тухай бүр нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн хөрөнгүүдийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

АВЛАГА.

Уг хөрөнгийг бодит үнэ цэнэ дээр тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан шууд зардлыг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрдөг.

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР.

Компани нь гаргасан өрийн бичиг, өр төлбөрийг тухайн ажил гүйлгээг үүссэн өдрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн өр төлбөрийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг.

САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙГ ЦЭВЭР ДҮНГЭЭР ТУСГАХ.

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

ҮНДСЭН ХӨРӨНГӨ

АНХДАГЧ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлсийг анхны удаа өртгөөр нь хэмждэг. Өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбогдон гарсан зардлууд багтдаг.

ДАРАА ҮЕИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөний дараа үндсэн хөрөнгийг түүний бодит үнэ цэнийг илтгэх дахин үнэлсэн дүнгээр хэмжих ба дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байдаг. Хөрөнгийн бодит үнэ цэнийг Монгол Улсын хараат бус гуравдагч этгээд тогтоодог.

ДАРАА ҮЕИЙН ЗАРДАЛ.

Дараа үеийн зардлыг зөвхөн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай гэдэг нь тогтоогдсон үед капиталжуулан бүртгэдэг. Урсгал засварын зардлыг гарсан тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

ЭЛЭГДЭЛ.

Үндсэн хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар элэгдүүлж, орлогын тайланд бүртгэдэг. Үндсэн хөрөнгийг түүнийг байршуулж, ашиглахад бэлэн болсон үеэс нь, дотооддоо барьж байгуулсан хөрөнгийн хувьд тэдгээрийг дуусгавар болгож, үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон үеэс нь эхлэн элэгдэл байгуулдаг.

БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Компани биет бус хөрөнгө худалдан авсан бөгөөд түүний ашиглалтын жилийг тодорхойлох боломжтой бол түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

БИОЛОГИЙН ХӨРӨНГӨ

Биологийн хөрөнгийг борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд үүнтэй холбоотой үүсэх олз ба гарзыг тухайн тайлант үеийн ашиг, алдагдалаар хүлээн зөвшөөрнө.

2.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

Компани бэлтгэл шаардагдах хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн хэсэг болгон капиталжуулдаг. Бусад зээлийн өртгийг гарсан тайлант үед нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.

ТҮРЭЭСИЙН ХӨРӨНГӨ

Түрээсийн хөрөнгөтэй холбоотой эрсдэл, эзэмшил компанид бүрэн шилжсэн гэж үзсэн тохиолдолд санхүүгийн түрээсээр ангилж, бүртгэдэг. Санхүүгийн түрээсийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө хөрөнгийн бодит үнэ цэнэ болон түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийн аль багаар бүртгэдэг.

БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнийн аль багаар үнэлдэг. Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардлууд ордог. Үйлдвэрийн бараа материал, дуусаагүй үйлдвэрлэлийн хувьд хэвийн хүчин чадлаар ажиллах үеийн үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын зохих хэсгийг өртөгт хуваарилдаг.

ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

ҮҮСМЭЛ БУС САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хөрөнгийн хувьд тэдгээрт үнэ цэнийн бууралт үүссэн гэдэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог

ХОРОГДУУЛСАН ӨРТГӨӨР ИЛЭРХИЙЛСЭН САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ.

Компани эдгээр хөрөнгүүдийг тусад нь мөн хамтад нь үнэ цэнийн бууралтын нотолгоо байгаа эсэхийг үздэг. Бүх мэдэгдэхүйц хэмжээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тусад нь үнэлнэ.

САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ.

Тайлант үеийн эцэст бараа материал, хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад санхүүгийн бус хөрөнгийн дансны үнэнд үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг

үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрсэн бол тухайн хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно.

АЖИЛЧДЫН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, УРАМШУУЛАЛ

АЖИЛЧДЫН БОГИНО ХУГАЦААТ ТЭТГЭМЖ. Холбогдох үйлчилгээ үзүүлсэн үед ажилчдын богино хугацаат тэтгэмжийг зардлаар бүртгэдэг. Компани нь ажилтны үзүүлсэн үйлчилгээний дагуу компанид үүрэг хариуцлага үүссэнээс найдвартайгаар тооцоолж болох компанийн төлөх ёстой дүнгээр өр төлбөрөө хүлээн зөвшөөрдөг.

ТОГТООСОН ШИМТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.

Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн Даатгалын Санд төвлөрүүлэх хуулиар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ. Тодорхой шимтгэлийн дүн бүхий тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөрт төвлөрүүлэх шимтгэлийг түүнийг төлөх үүрэг хүлээсэн тайлант үеийн зардлаар бүртгэдэг.

НӨӨЦ БА БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Компани өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед санхүүгийн байдлын тайланд нөөцийг хүлээн зөвшөөрдөг

ХУВЬЦААТ КАПИТАЛ

ЭНГИЙН ХУВЬЦАА.

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж, бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

ХАЛААСНЫ ХУВЬЦАА.

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татварын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бууралт гэж бүртгэдэг.

Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд халаасны хувьцаа гэж тайлагнадаг. Халаасны хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэнд гаргасан

2.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөөд тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

ОРЛОГО

Бараа борлуулалтын орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж бүртгэлд тусгадаг. Ингэхдээ компани эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлал өндөр бөгөөд орлого ба өртөг зардлыг бодитоор хэмжих боломжтой байх ёстой.

БАРАА БОРЛУУЛАЛТ.

Бараа агуулахаас ачигдан, худалдан авагчийн талбайд хүргэгдэж, худалдан авагч барааг хүлээн авч, эрсдэл болон өмчлөл нь худалдан авагчид бүрэн шилжсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрдөг. Орлогын дүнд нэмэгдсэн өртгийн албан татвар болон бусад борлуулалтын татварыг оруулдаггүй ба худалдааны хөнгөлөлт, урамшууллыг хассан цэвэр дүн байдаг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮРЭЭСИЙН ОРЛОГО.

Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид төлөгдөх ижил хэмжээний хэсэгчилсэн төлөлтөөр орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн хөрөнгийн урамшууллыг түрээсийн нийт зардлын дүнд тооцон түрээсийн хугацааны туршид хүлээн зөвшөөрдөг. Болзошгүй түрээсийн орлогыг тухайн орлогыг олсон тайлант хугацаанд хүлээн зөвшөөрдөг.

БУСАД ОРЛОГО.

Компаний үндсэн үйл ажиллагаанаас гадна бий болж буй орлогыг бусад орлого гэх бөгөөд тухайн орлогын эдийн засгийн өгөөжийг компани хүртэх магадлалтай ба үүнийг найдвартай хэмжин тодорхойлох боломжтой болсон үед компани бусад орлогыг хүлээн зөвшөөрдөг.

ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР

Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулж, ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Хүлээн авсан түрээсийн урамшууллыг түрээсийн хугацаанд нийт

түрээсийн зардлын нэг хэсэг хэмээн хүлээн зөвшөөрдөг.

САНХҮҮГИЙН ОРЛОГО БА САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтаас хүртэх хүүгийн орлого орно. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд хуримтлуулан бүртгэдэг. Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрддэг. Зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, орлогын тайланд бүртгэдэг.

ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Тайлант жилийн татвар болон хойшлогдсон татварыг эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоор шууд хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ

Компани энгийн хувьцааны хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог.

ХОЛБООТой ТАЛУУД

Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг;
- Компанид мэдэгдэхүйц нөлөөлөлтэй;
- Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь компанитай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж болзошгүй гэр бүлийн гишүүд юм.

ТАЙЛБАР ТОЛЬ

Тайлант үе

Аж ахуйн нэгж, байгууллагын ашиг, алдагдлыг тооцож буй хугацааг хэлнэ. Ерөнхийдөө улирал, жилийг хамруулж авч үзнэ.

Санхүүгийн тайлан

Иж бүрэн санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдэнэ.

Хөрөнгө

Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болж, байгууллагын мэдэлд орсон бөгөөд ирээдүйд үр өгөөжөө өгөх нөөц, баялаг, хөрөнгө юм.

ББХ-Биет бус хөрөнгө

Үндсэн хөрөнгөтэй адил биетээр, бодитоор оршдоггүй хэдий ч эзэмшигчиддээ давуу тал болон давуу эрхийг олгодог патент, лиценз, зохиогчийн эрх, барааны тэмдэг, нэр төр, гүдвил гэх мэт удаан хугацаанд үнэ цэнэтэй байх актив (хөрөнгө)-ыг хэлнэ.

ҮХ-Үндсэн хөрөнгө

Байшин, барилга, машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил гэх мэт худалдан борлуулах зориулалтгүй, үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаанд урт хугацаанд ашиглагдах буюу 1 жилээс бага хугацаанд борлогдож мөнгөн хөрөнгө болохгүй хөрөнгийг хэлнэ.

ЭБХ-Эргэлтийн бус хөрөнгө Үндсэн хөрөнгийг хэлнэ.

ЭХ-Эргэлтийн хөрөнгө

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад ашиглагдах нэг жил буюу түүнээс бага хугацаанд бэлэн мөнгө болж хувирах хөрөнгийг хэлнэ.

УТЗ-Урьдчилж төлсөн зардал

Ажил үйлчилгээ авахаас өмнө буюу үр дүн нь гарахаас өмнө төлсөн төлбөр эрсдэлийн зураглал

Дансны Авлага

Үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах мөнгөн дүн.

Бусад санхүүгийн хөрөнгө

3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат хөрөнгө оруулалт хамаарна.

Мөнгөтэй түүнтэй адилтгах хөрөнгө

Үнэ цэнийг нь өөрчлөхөд өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөнд шууд хөрвөх нэгээс гурван сарын хугацаатай хөрөнгө оруулалт юм.

Мөнгөн суурьт арга

Бэлнээр мөнгө хүлээж авсан үед нь орлогод, бэлнээр мөнгө төлсөн үед нь зардалд бүртгэх нягтлан бодох бүртгэлийн арга.

Аккрузал суурьт арга

Мөнгө хүлээн авсан, эсхүл төлснөөс үл хамааран ажил үйлчилгээний гүйцэтгэлтэй уялдуулан орлогыг олсон, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

Хувьцаат капитал

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө юм.

Дахин үнэлгээний нөөц

Аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн дүнг хэлнэ.

Өр төлбөр

Бусдад төлөх ёстой мөнгө (хувь хүн, компани, эсхүл Засгийн газрын өр байж болно).

Урт хугацаат өр төлбөр

Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийг хэлнэ.

Богино хугацаат өр төлбөр

12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг хэлнэ.

ТАЙЛБАР ТОЛЬ

НДШ-Нийгмийн даатгалын шимтгэл

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг санхүүжүүлэх зорилгоор ажилчид болон ажил олгогчдод ногдуулах татвар.

ОТ-Орлогын тайлан

Компанийн олсон орлого, гаргасан зардлыг тодорхой хугацаагаар (улирал, жил) тасалбар болгон харуулсан тайлан

Борлуулалтын орлого

Тайлангийн хугацаанд худалдсан бараа, бүтээгдэхүүн үйлчилгээний үйл ажиллагаанаас олсон орлогыг хэлнэ.

ББӨ

Тайлант үед борлуулсан барааны өртгийг хэлнэ.

НА

Байгууллагын тодорхой хугацаан дахь үйл ажиллагааны үр дүнгийн мөнгөн илэрхийлэл буюу бизнес эрхэлж, эрсдэл хүлээсний төлөө авч буй үр өгөөж, компанийн нийт орлогоос бүх мөнгөн болон хийсвэр зардлыг хасч тооцно.

ҮАЗ-Үйл ажиллагааны зардал

Бизнес эрхлэхэд гарч буй зардал.

ХТӨА

Хүү татварын өмнөх ашиг

ЦА

Компанийн орлогоос бүх төрлийн зардал болон татварыг хасаад үлдэж буй ашгийн хэмжээ.

Татварын хувь хэмжээ

Орлогын албан татварын зардал нь орлогын албан татварын өмнөх ашиг нь хувиар илэрхийлсэн

ОАТ

Засгийн газраас аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогод ногдуулж буй татвар

МГТ-Мөнгөн гүйлгээний тайлан

Байгууллагын тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг харуулсан тайлан

ҮҮАМГ

Үндсэн Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ байгууллагын орлого олох үндсэн үйл ажиллагаанаас орж ирэх мөнгөн хөрөнгийг хэлнэ



APU COMPANY

Absolute. Pure. Unique.

Монгол улс, Улаанбаатар хот 17040,
Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 48.
Утас: 11-344837
www.apu.mn